

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ  
(Илтгэх хуудас)**

**НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

**1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт**

1.1.Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан тусгай арга хэмжээнээс бусад **27 нийт арга хэмжээ болон нэмэлтээр үүрэг болгосон 2 арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

<b>Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо</b>	<b>Өгвөл зохих оноо</b>	<b>Өгсөн оноо /дундаж оноо/</b>
1	2	3
	0-30	

1.2.Гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон **2 тусгай арга хэмжээ (гарц)-ний** хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 2

<b>Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо</b>	<b>Өгвөл зохих оноо</b>	<b>Өгсөн оноо /дундаж оноо/</b>
1	2	3
	0-40	

1.3. **Манлайллын зорилт (орц)** бүрийн биелэлтийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 3

<b>Манлайллын зорилт (орц)-ын тоо</b>	<b>Өгвөл зохих оноо</b>	<b>Өгсөн оноо /дундаж оноо/</b>
1	2	3
	0-30	

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт /өөрийгөө хөгжүүлэх/-ын биелэлт:

.....  
.....  
.....

1.5. Тухайн төсвийн шууд захирагчийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажилласан тухай дүгнэлт:

.....  
.....  
.....

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт:

.....  
.....  
.....

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

### 3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

Гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо/
1.Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт	0-30	
2.Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	0-40	
3.Манлайллын зорилт (орц)-ын биелэлт	0-30	
<b>Нийт оноо</b>	0-100	

3.2.Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээгээ

гэж тэмдэглэнэ.

Хүснэгт 5

"А" буюу "Маш сайн"	"В" буюу "Сайн"	"С" буюу "Хангалттай"	"D" буюу "Дутагдалтай"	"F" буюу "Хангалтгүй"
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хэрэв "А" буюу "Маш сайн", эсхүл "D" буюу "Дутагдалтай", "F" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ:

.....  
.....  
.....  
.....

**4. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:**

1).....  
.....

2).....  
.....

..... Г.М.

**5. Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт:**

5.1. Үнэлгээ өгсөн:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ ..... / С.БАТБОЛД/

(албан тушаал)  
(тэмдэг)

(гарын үсэг)  
.....  
(Огноо)

5.2. Үнэлгээтэй танилцсан:

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА ..... /Э.БОЛОРМАА/

(албан тушаал)  
(тэмдэг)

(гарын үсэг)  
.....  
(Огноо)

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:****2017 он**

Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)	Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)
1	2	3
<b>Зорилт 1: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд тулгуурлан төлөвлөж, цахим хэлбэрээр зохион байгуулна.</b>		
1.1 Худалдан авах ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, үнэлгээний хороо байгуулна.	Нийслэлийн хэмжээнд 2017 онд хэрэгжих худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлангах” журмын нэгдүгээр хавсралт "маягт-1"-ийн дагуу боловсруулан 2016 оны 12 сарын 16-ны өдрийн 01/4278 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлсэн. Тус газраас хуулийн дагуу төрийн бус байгууллага, НИТХ-ын тогтоолоор батлагдсан АЗ гэрчилгээтэй иргэдийн төлөөлөлтэй зөвшилцсөнөөр үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилсон 113 удаагийн тушаал баталсан. Үүнд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 40 удаагийн тушаал багтаж байна.	

<p>1.2 Худалдан авах ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулж, бүтээн байгуулалтын ажлыг эрт эхлүүлнэ.</p>	<p>Гэрээ байгуулах шатанд шилжсэн 327 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд зарцуулсан хугацааг тооцож үзвэл Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай захирамж гарснаас үнэлгээний хороо байгуулах хүртэл дунджаар ажлын 2 өдөр, үнэлгээний хороо байгуулагдсан өдрөөс тендер зарлах хүртэл дунджаар ажлын 5 өдөр, тендер нээсэн өдрөөс захиалагчид гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлэх хүртэл дунджаар ажлын 41 өдөр, худалдан авах ажиллагааны зохион байгуулалтад дунджаар ажлын 28-57 өдрийг зарцуулж ажилласан байна.</p> <p>Ажил удааширч буй гол шалтгаан нь захиалагч байгууллагаас зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж байгаа, гомдол үүсч, дахин зарлах болсонтой холбоотой байна. Үүнээс зураг төсөв, ажлын даалгавар хүлээгдэж байгаатай холбоотой удааширсан ажлын хувьд авч үзвэл, худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай захирамж гарснаас ажлын 37-89 өдрийн дараа захиалагч байгууллагаас зураг, төсөв ирүүлсэн 17 төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал, Зайсангийн авто замаас “Зайсангийн толгойн урдуур Богд уулын арын авто замтай холбогдох авто зам 2.4 км автозам”-ын ажлын зураг, төсвийг захиалагч байгууллагаас ажлын 89 өдрийн дараа ирүүлсэн байна.</p> <p>Тайлант хугацаанд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гомдол хянагдаж тендерийн нээлт 10-16 ажлын өдрөөр хойшилсон 20, Сангийн яаманд гомдол үүссэнтэй холбоотой нийт 65 төсөл, арга хэмжээнээс 32 төсөл арга хэмжээний хүчинтэй хугацааг сунгасан байна. Мөн дахин зарлахаар шийдвэрлэгдсэн 10, тендерийн үнэлгээг дахин хийхээр шийдвэрлэсэн 27 төсөл арга хэмжээний зохион байгуулалтын хугацаа удаарширсан байна. Тендерийн үнэлгээ дахин хийсэн 27 төсөл, арга хэмжээ байгаа ба энэ хугацаанд тендерийн хүчинтэй хугацаа дуусч дахин зарлагдсан 4 төсөл, арга хэмжээ байна.</p> <p>Тайлант хугацаанд нийт 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Үүнээс нийт ажлын 21 хувь буюу 72 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай холбоотой гомдол үүссэн. Мөн 354 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад 1295 аж ахуйн нэгж санал ирүүлж оролцсон ба үүнээс шалгараагүй 941 аж ахуйн нэгжийн 10 хувь буюу 88 аж ахуйн нэгж гомдол гаргаад байна.</p>	
<p>1.3 Худалдан авах ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллага,</p>	<p>Үнэлгээний хороонд олон нийтийн төлөөлөлөөр ажилласан цагийг үндэслэн ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх хэмжээ буюу 3156 төгрөгийн</p>	

<p>мэргэжлийн төлөөллийг урамшуулал олгон, дэмжиж ажиллана.</p>	<p>урамшуулал хөлс олгож байна. Үүний дагуу 2017 онд давхардсан тоогоор 54 төлөөлөлд 2,414,202.0 төгрөгийн урамшуулал олгоод байна.</p>	
<p>1.4.Захиалагч, тендерт оролцогчдын төлөөллийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.</p>	<p>а) Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллага, Дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны 9 албанд 2017.06.16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр зөвлөмж, чиглэл хүргүүлж ажилласан. Үүнд, Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ийг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д ил тод, нээлттэй мэдээлэх, Сангийн сайдын 2013 оны “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын дагуу биелэлтийг тайлагнах үүрэг чиглэлийг багтаасан юм.</p> <p>б) Нийслэлд 2017 онд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг эрчимжүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын 2017.06.15-ны өдрийн А/447 дугаар захирамжийг батлуулан, хэрэгжилтийг хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>в) Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.</p>	

	<p>г) 2017.10.26-ны өдөр “Тендерт хэрхэн амжилттай оролцох вэ?” сэдэвт сургалтыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, “Хамтын хөгжлийн мэргэшсэн институт” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Уг сургалтад 42 аж ахуйн нэгж, иргэн хамрагдаж, цахим систем ашиглалттай холбоотой заавар зөвлөмж, системийн шинэчлэлтийн талаар мөн Сангийн яаманд үүсч буй гомдол маргааны шалтгаан, тендерт оролцогчийн анхаарах зүйлсийн талаар бодит судалгаа, баримт бүхий мэдээлэл хүргэж ажилласан.</p> <p>д) 2017.11.23 өдрийн 147 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг төлөвлөж хөтөлбөр баталсан. Уг хөтөлбөрийн дагуу 2017 оны 12 сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Уг сургалтанд Нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.</p>	
<p>1.5.Тендерийн урилга, зарыг өдөр тутмын сонин болон цахим системд нийтлэх ба Газрын үйл ажиллагаа, тендерийн явц, үр дүнгийн талаар иргэд олон нийтэд нээлттэй мэдээлнэ.</p>	<p>а) Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын талаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “2017 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-г Сангийн яамнаас батласан маягт 1-ийн дагуу батлуулан “Өдрийн сонин”-ы 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн №004/5570 дугаарт болон худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д 2017 оны 01 сарын 15-ны өдрийн дотор нийтлэж, олон нийтэд мэдээлсэн.</li> <li>- Тайлант хугацаанд 230 удаагийн тендерийн урилга, зарыг өдөр тутмын сонинд зарлан мэдээлсэн. Үүнд, эхний улиралд “Өдрийн сонин”-д 38, “УВ пост” сонинд 11 удаа тендерийн урилга, зар нийтлүүлсэн. 2017 оны 2 дугаар улирлаас өдөр тутмын сонинтой хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, “Засгийн газрын мэдээ”</li> </ul>	

	<p>сонинд 52, “Улс төрийн тойм” сонинд 47, “Монголын мэдээ” сонинд 64, “Өнөөдөр” сонинд 18 удаагийн тендерийн урилга, зар нийтлээд байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 174,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ</li> <li>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 23,451.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусгасан.</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн тендер шалгаруулалтын онцгой журам буюу харьцуулалтын аргаар 65 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a>-д цахим системүүдэд олон нийтэд ил тодоор зарласан.</li> <li>- Худалдан авах ажиллагааны 2016 оны жилийн тайлан болон 2017 оны сар тутмын явцын мэдээлэл болон эхний хагас жилийн дэлгэрэнгүй тайлан мөн худалдан авах ажиллагаанд хийсэн Аудитын дүгнэлт, зөвлөмжийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a> –д тухай бүр нийтлэн, ил тод нээлттэй мэдээлж байна.</li> <li>- “Шилэн дансны тухай хууль”, “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын дагуу 152,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 327 төсөл, арга хэмжээний тендерийн үр дүнг <a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a> болон <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a>-д цахим системд нийтлэн, ил тод мэдээлээд байна.</li> </ul> <p>б) Байгууллагын үйл ажиллагааны талаар:</p>	
--	---	--



	<ul style="list-style-type: none"> <li>- 2017 оны 02 сарын 20 өдрийн “Улаанбаатар хөрөнгө оруулалт” бизнес чуулга уулзалтын үеэр “Худалдан авах ажиллагааны ил тод байдал” сэдвээр илтгэл тавьж, нийт оролцогч аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэсэн. Мөн уг өдөрлөгийн оролцогчдод тараагдсан “Монголиа экономи” сэтгүүлийн тусгай дугаарт нийтлэл өгч, хамтран ажилласан.</li> <li>- “Өдрийн сонин”-ы 2017 оны 2 сарын 27-ны өдрийн дугаарт дарга Э.Болормаа Нийслэлд 2017 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны талаар ярилцлага нийтлүүлж, хамтран ажилласан.</li> <li>- Засгийн газар, нийслэлээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2017 оны 05 сарын 15-ны өдрийн 10-17 цагийн хооронд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож, тендерт оролцогч 23 аж ахуйн нэгж болон 11 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Энэ үеэр “Монгол” телевиз, “Эх орон” телевиз, MNC телевиз, ТМ телевиз, UBS телевиз, TV5 телевиз, Монголын радио, Үндэсний шуудан сонинтой тус тус хамтран ажиллаж, худалдан авах ажиллагааны талаар төрөөс баримтлаж буй бодлого, шинээр нэвтрүүлсэн ажил болон 2017 онд нийслэл хотод хэрэгжиж буй худалдан авалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан.</li> <li>- “Засгийн газрын мэдээ”-ы 2017 оны 2 сарын 27-ны өдрийн дугаарт дарга Э.Болормаа худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, цахим систем болон салбарын бодлого шийдвэрийн талаар ярилцлага нийтлүүлж, хамтран ажилласан.</li> <li>- Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын цахим хуудсын стандартын дагуу хөтлөж, 2017 онд шинэчлэн баталсан “Мэдээллийн технологийн аюулгүй байдал ба мэдээллийн ил тод байдлын тухай журам-ын дагуу үйл ажиллагаа, хүний нөөц, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээлэл, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, журам жишиг бичиг баримт болон төсөв санхүүгийн мэдээллийг тухай бүр ил тод, нээлттэй байдлаар нийтлэн ажиллаж байна.</li> <li>- 2017 оны 04 сард Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол Баянзүрх дүүргийн иргэдтэй хийсэн уулзалтад Газрын дарга Э.Болормаа, Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн дарга Б.Түмэнжаргал нар оролцож, тус дүүрэгт 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө</li> </ul>	
--	---	--

	<p>оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, биелэлтийн явцыг танилцуулах, мэдээлэл өгч хамтран ажиллав. Уулзалтын үеэр тус дүүргийн 8 дугаар хорооны иргэн М.Энхбаярын хүсэлтээр “Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр гэр хорооллын дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Улаанхуаран дэд станцаас 5 мВт цахилгаан хэрэглээг хангах кабель шугам татах ажил”-ын явц болоод төсөв хөрөнгийн шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 2017 оны 03 сар, 05 дугаар сард Нийслэлийн Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалтад Газрын дарга Э.Болормаа, Орлогч дарга Б.Гүндсамбуу нар оролцож, нийслэлд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт ба зохион байгуулалт, биелэлтийн явцыг танилцуулж, иргэдийн хүсэлтээр дүүрэг, хороодод хэрэгжиж буй зарим ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч хамтран ажиллав. Уулзалтын үеэр Сүхбаатар дүүргийн гэр хороололд оршин суугч иргэдийг төлөөлж иргэн Н.Батбаяр “...гэр хорооллын доторх гудамж, зам талбайн тохижилт, сул шороо болон гэрэлтүүлэгтэй холбоотой энэ онд хийгдэх ажлын талаар” мэдээлэл хүссэн. Газрын дарга Э.Болормаа Сүхбаатар дүүргийн төсвийн хөрөнгөөр энэ онд 5, 7, 10, 12, 15, 17, 18, 20 дугаар хороодод тохижилтын ажил хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.</li> <li>- Худалдан авах ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны талаар 8 удаагийн мэдээ мэдээллийг социал сүлжээнд нийтлэж, олон нийтэд сурталчилсан.</li> </ul>	
<p>1.6. Худалдан авах ажиллагааг цахим систем ашиглан зохион байгуулна.</p>	<p>а) Улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. Үүнээс сонгон шалгаруулалтыг зарлаж эхлүүлсэн 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулсан. Төрийн нууцтай холбоотой болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа нь олон улсын журмаар зохион байгуулагдсан тул уг системээр тендерийг зарлаагүй.</p>	

	<p>б) Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, захирамж гаргасантай холбоотой Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтын дагуу Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ийг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a> -д ил тод, нээлттэй мэдээлэх, биелэлтийг тайлагнах талаар 2017.06.16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 11 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад зөвлөмж чиглэл хүргүүлсэн.</p> <p>в) Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.</p> <p>г) 2017.11.23 өдрийн 147 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг төлөвлөж хөтөлбөр баталсан. Хөтөлбөрийн дагуу 2017 оны 12 сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль эрхзүйн</p>	
--	--	--

	<p>хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Уг сургалтанд Нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.</p>	
<p>1.7. Засгийн газраас хэрэгжүүлж буй "Цахим тендер-2" төслийг Нийслэлийн хэмжээнд нэвтрүүлж, дүүргийн ХАА-ны албадад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>а) Сангийн яамны Хууль Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй хамтран 2017.03.31 өдөр "Тогтвортой худалдан авалт" сэдэвт сургалт зохион байгуулж, 9 Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын 19 мэргэжилтэнийг хамруулсан.</p> <p>б) Хууль, журам, зааврын хэрэгжилтийг хангах, төрийн байгууллага хоорондын уялдааг сайжруулах зорилгоор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын дарга нартай хийх уулзалтын удирдамжийг 2017 оны 02 сарын 23-ны өдөр батласан. Үүний дагуу 2017 оны 03 сарын 14-ний өдрийн 09-12 цагийн хооронд уулзалт зохион байгуулж, 9 Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын дарга, ахлах мэргэжилтэн 14 албан хаагчид худалдан авах ажиллагааг зохион байгуулахад гарч буй хүндрэлийн талаар санал солилцон, цаашид худалдан авах ажиллагааг ил тод, шуурхай, богино хугацаанд зохион байгуулахад анхаарах асуудлаар зөвлөмж, чиглэл өгч ажилласан.</p> <p>в) Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны ерөнхий болон дэлгэрэнгүй төлөвлөгөөг үүсгэх, батлах, Сангийн яаманд маягтын дагуу тайлбар хүргүүлэн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргийн албадад эрх шилжүүлэх болон цахим системийг ашиглах, тендер шалгаруулалтыг эхлүүлэх, урилга, зар нийтлэх, тендерийн баталгаа цуцлах, сонгон шалгаруулалтын үр дүнг мэдээлэх зэрэгт зөвлөгөө, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна.</p> <p>Үүнд, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай" 6/11 дүгээр тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 174,400.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ буюу Нийслэлийн Засаг даргаас батласан "Худалдан авах ажиллагааны 2017</p>	

	<p>оны ерөнхий төлөвлөгөө”-г 2017.01.15 өдрийн дотор уг системд нийтлэж, олон нийтэд зарласан.</p> <p>- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 23,451.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд нэмж тусган захирамжийн дагуу эрх шилжүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улсын төсвийн 15,520.4 сая төгрөгийн 67, нийслэлийн төсвийн 395,776.2 сая төгрөгийн 661 төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтлэн, Сангийн яамаар батлуулах, захирамжийг үндэслэн эрх шилжүүлэлтийг хийх мөн Дүүргийн Засаг дарга нараас эрх шилжүүлсэн 24,373.8 сая төгрөгийн 402 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээр дамжуулан батлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Төсвийн тодотгол болон төсөл, арга хэмжээг багцлах, задлах, эрх шилжүүлэхтэй холбоотой 68 удаа системд заасан маягтын дагуу Сангийн яаманд хүсэлт гаргаж, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, ажилласан.</p> <p>г) Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, захирамж гаргасантай холбоотой Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтын дагуу Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ийг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a> -д ил тод, нээлттэй мэдээлэх, биелэлтийг тайлагнах талаар 2017.06.16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр нутгийн</p>	
--	---	--

	<p>захиргааны 11 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад зөвлөмж, чиглэл хүргүүлсэн.</p> <p>д) Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.</p>	
<p>1.8. Нийслэлийн хэмжээнд <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a> системийг нэвтрүүлж, худалдан авах ажиллагааны мэдээллийг хуульд заасны дагуу ил тод мэдээлнэ.</p>	<p>а) Нийслэлийн Засаг даргаас батласан “Худалдан авах ажиллагааны 2017 оны ерөнхий төлөвлөгөө”-г 2017.01.15 өдрийн дотор уг системд нийтлэж, олон нийтэд зарласан.</p> <p>б) Нийслэлийн Засаг даргаас эрх шилжин ирсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 152,431.9 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 83,906.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 335 төсөл, арга хэмжээг 100 хувь цахим систем / <a href="http://www.ub-procurement.mn/">www.ub-procurement.mn/</a>-ээр зохион байгуулж байна.</p> <p>в) Тус газарт хэрэгжиж буй 52,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий бүхий 327 төсөл, арга хэмжээний тендерийн үр дүнг <a href="http://www.tender.gov.mn/">www.tender.gov.mn/</a>, цахим систем болон байгууллагын цахим хуудас <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a>, <a href="http://www.shilendans.mn/">www.shilendans.mn/</a>-д нийтлэн, ил тод мэдээлээд байна.</p>	
<p>1.9. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>Шилэн дансны тухай хууль, “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг хангах арга хэмжээний хүрээнд “shilendans.gov.mn” цахим хуудаст жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас жилийн гүйцэтгэл, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар улирлын гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хагас жилийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, орлого зарлагын мөнгөн гүйлгээ</p>	

	<p>зэргийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийн хамт байршуулан мэдээлж байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “2017 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-г Сангийн яамнаас баталсан маягт1-ийн дагуу нийтлэж, олон нийтэд мэдээлсэн.</li> <li>- Тус газарт хэрэгжиж буй 52,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий бүхий 327 төсөл, арга хэмжээний тендерийн үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, цахим систем болон байгууллагын цахим хуудас <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a>, <a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a>-д нийтлэн, ил тод мэдээлээд байна.</li> <li>- Нийслэлийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2017.04.20 өдрийн А/13 тушаалаар батлагдсан “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-г мэдээлсэн.</li> <li>- Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлт, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, 2017 оны 1-12 сарын Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хөрөнгө мөнгөний зарцуулалтай холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш төгрөгийн гүйлгээ, аудитын газрын акт, тайлан, менежментийн захидал, аудитын гэрчилгээ зэргийг тухай бүрд нийтлэх мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол мэдээлэн ажиллаж байна.</li> <li>- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус бүр хуулийн хугацаанд багтаан мэдээлж байна.</li> </ul>	
<p>1.10. Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.</p>	<p>а) Тайлант хугацаанд Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн улсын төсвийн 15,520.4 сая төгрөгийн 67, нийслэлийн төсвийн 395,776.2 сая төгрөгийн 661 төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтлэн, Сангийн яамаар батлуулах, захирамжийг үндэслэн эрх шилжүүлэлтийг хийх мөн Дүүргийн Засаг дарга нараас эрх шилжүүлсэн 24,373.8 сая төгрөгийн 402 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээр дамжуулан батлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Төсвийн тодотгол болон төсөл,</p>	

	<p>арга хэмжээг багцлах, задлах, эрх шилжүүлэхтэй холбоотой 68 удаа системд заасан маягтын дагуу Сангийн яаманд хүсэлт гаргаж, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, ажилласан.</p> <p>б) Тус газарт хэрэгжиж буй 52,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий бүхий 327 төсөл, арга хэмжээний тендерийн үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, цахим систем болон байгууллагын цахим хуудас <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a>, <a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a>-д нийтлэн, ил тод мэдээлээд байна.</p> <p>в) Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлж, захирамж гаргасантай холбоотой Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.6.5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1-32 дахь заалтын дагуу Засгийн газраас нэвтрүүлж буй худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ийг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Сангийн сайдын 2013 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээллэх журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a> -д ил тод, нээлттэй мэдээлэх, биелэлтийг тайлагнах талаар 2017.06.16 өдрийн 01/828 дугаар албан бичгээр нутгийн захиргааны 11 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад зөвлөмж чиглэл хүргүүлсэн.</p> <p>г) Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, үр дүнг тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.</p>	
--	--	--



<p>1.11. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол, маргааныг хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.</p>	<p>Тайлан хугацаанд 354 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан ба 72 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалттай холбоотой давхардсан тоогоор 87 удаа гомдол гарсан байна. Гомдол, маргааныг хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлж, шаардлагатай баримт материалыг хүргүүлэн ажиллаж байна. Үүнээс Сангийн яаманд 65, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 20, Шүүхэд 12 гомдол тус тус гарсан. Сангийн яамнаас “Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй”-23, “Захиалагчийн шийдвэрийг хүчингүй болгон, дахин зарлах”-27, “Тендерийг дахин үнэлэх”-ээр шийдвэрлэсэн 10, гомдол шийдвэрлээгүй хянан үзэж байгаа 5 ажил байна. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас “ТШӨХ-т өөрчлөлт оруулан дахин зарлах” 10, “Тендерийг хэвээр үргэлжлүүлэх” 10 ажил байна. Шүүхээр шийдвэрлүүлсэн гомдлын тухайд, НХААГ-ын гаргасан шийдвэр үндэслэлтэй- 6, НХААГ-ын гаргасан шийдвэр үндэслэлгүй- 1, Шийдвэр гараагүй- 5 ажил байна.</p>	
<p>1.12. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль" болон холбогдох журмыг боловсронгуй болгоход саналаа тусгана.</p>	<p>а) Монгол улсын Сангийн яамны 2017.05.23-ны өдрийн 176 дугаар албан бичгээр “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус Газрын дарга Э.Болормаа томилогдон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 8 дугаар сард багтаан боловсруулж, Сангийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна. Үүнтэй холбоотой тус газрын Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтэс, Хууль, хяналтын хэлтсээс “Аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын эрх, үүрэг”-ийг хуульчлах талаарх шаардлага, үндэслэлийг боловсруулж, 2017 оны 06 сарын 13-ны өдөр ажлын хэсэгт танилцуулж ажилласан.</p> <p>б) “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг салбарын албан хаагчид болон тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлгийн дүн, саналыг нэгтгэн 2017 оны 09 сарын 19-ний өдрийн 02/1573 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Уг хэлэлцүүлэг нь тус байгууллагын болон Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын дарга, ахлах</p>	

	<p>мэргэжилтнүүдийг хамруулан 2017.09.05-ны өдөр, тендерт оролцогч 32 аж ахуйн нэгжийг хамруулан 2017.09.06-ны өдөр тус тус зохион байгуулагдсан.</p> <p>в) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тендерийн жишиг баримт бичигт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 02/1758 дугаар албан бичгээр Монгол улсын Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>г) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг 2017 оны 11 сарын 11-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p>	
<p>1.13. Дээд шатны болон хяналт шалгалтын байгууллагаас гаргасан чиглэл, зөвлөмж зааврын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.</p>	<p>а) Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 2017 оны 1 дүгээр сарын 31 өдрийн 03/418 тоот албан бичгээр ирүүлсэн 2016 оны үйл ажиллагааг үнэлж, шалган, зааварласан зөвлөмжийн дагуу 2017.03.21 өдрийн А/44 тушаалаар “Үйл ажиллагааг үнэлж, шалган, зааварласан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>б) Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн илтгэх хуудас болон байгууллагын үйл ажиллагааны жилийн тайланг Засгийн газрын 2017 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжид заасан чанар стандартад нийцүүлэхийн тулд байгууллагын дотоодод “Үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” журам батлаж, биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>в) “Үйл ажиллагааг үнэлж, шалган, зааварласан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний биелэлтийг 2017 оны 07 сарын 06-ны өдрийн 01/1025 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлж ажилласан. Уг төлөвлөгөөний биелэлтийн жилийн тайланг 2017 оны 12 сарын 20-ны өдрийн дотор тус хэлтэст хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.</p>	
<p>1.14. Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах худалдан авах ажиллагааны тайлан</p>	<p>а) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйл, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тогтоолоор батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Нийслэлийн</p>	

<p>мэдээг хууль, журмын хүрээнд нэгтгэн холбогдох газруудад хүргүүлж ажиллана.</p>	<p>Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1148 дугаар захирамжийн дагуу сар, улирал, хагас болон жилийн байдлаар нийслэлийн нутгийн захиргааны 12 байгууллагад хэрэгжиж буй 284 төсөл, арга хэмжээ, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албанд хэрэгжиж буй 518 төсөл, арга хэмжээний явцын тайлан мэдээ, тус байгууллагад эрх шилжин зохион байгуулагдаж буй 355 төсөл, арга хэмжээний тайлан мэдээг нэгтгэн, бүртгэл хөтлөж байна. Үүнд, Монгол Улсын Сангийн яаманд “Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайлан”-г 2017.01.13 өдрийн 01/32 дугаартай албан бичгээр, “Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг 2017.04.10 өдрийн 01/276 дугаар албан бичгээр, “Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг 2017.07.06-ны өдрийн 01/1028 дугаар албан бичгээр, “Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг 2017.12.15-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. Мөн нийслэлд хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны сарын тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн засаг даргын Тамгын газар болон Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Төрийн сангийн хэлтэст сар бүрийн 05-ны өдрийн дотор албан бичгээр болон цахим хэлбэрээр тус тус хүргүүлж байна.</p> <p>в) Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.</p>	
--	---	--

	<p>г) 2017.11.23 өдрийн 147 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх, цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг төлөвлөж хөтөлбөр баталсан. Хөтөлбөрийн дагуу 2017 оны 12 сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Уг сургалтанд Нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагчийг хамруулж, гарын авлагаар хангаж ажилласан.</p>	
<p><b>Зорилт 2: Үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн, нийгмийн хариуцлагатай, шинэлэг худалдан авалт зохион байгуулна.</b></p>		
<p>2.1. Бүтээн байгуулалтын ажлын тендер бүрт дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор дотоодын давуу эрх тооцно.</p>	<p>а) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн “Тендерт оролцогчдод давуу эрх олгох тухай заалт”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 259 төсөл, арга хэмжээнд “Дотоодын давуу эрх тооцох”-оор тендер зарласнаас 151 төсөл, арга хэмжээнд Дотоодын давуу эрх тооцуулахыг тусгасан санал ирүүлсэн. Үүнээс шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж нотлох баримтыг бүрэн ирүүлсэн 10 саналыг дэмжиж, давуу эрх тооцоод байна.</p> <p>б) Дүүргийн албадын үйл ажиллагаатай танилцах, хууль журмын хэрэгжилт, үйл ажиллагааны хөтөлбөр болон үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт, дүгнэлт хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх тухай 2017.10.16-ны өдөр удирдамж баталж, ажлын хэсгийг томилсон ба 2017.11.01-ний өдрөөс 2017.11.07-ны хооронд Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаатай танилцаж, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, дотоодын давуу эрх тооцсон эсэх, үнэлгээний хороо байгуулах болон тендерийн сонгон шалгаруулалт, үнэлгээг хууль, журмын дагуу хийсэн эсэх талаар</p>	

	хяналт шалгалт хийж, хууль журмын хэрэгжилтийг дээшлүүлэх талаар заавар, зөвлөмж өгч ажилласан.	
2.2. Байгальд ээлтэй техник технологийг дэмжсэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.	<p>а) Нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр агаар орчны бохирдлыг бууруулах, ажлын хүрээнд 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнээс гэрээ байгуулагдаж худалда авах ажлилагаа хэрэгжиж дууссан 9, тендерийн материал хүлээн авч байгаа 2, захиалагч байгуулагаас зураг, төсөв хүлээгдэж байгаа 1 ажил, нийт 84,2 хувьтай хэрэгжиж байна.</p> <p>б) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 154 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд дараах 2 заалтыг оруулан байгальд ээлтэй техник, технологийг дэмжин ажилласан. Үүнд:</p> <p>-Уг ажлыг гүйцэтгэхэд ашиглагдаж буй материал түүхий эд болон тухайн ажлыг гүйцэтгэх менежмент нь байгаль орчинд ээлтэй технологиор гүйцэтгэсэн бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.</p> <p>-Уг ажлыг гүйцэтгэхэд шинэ, дэвшилтэт техник технологи ашигласан бол энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.</p> <p>Тайлант хугацаанд байгальд ээлтэй, шинэ, дэвшилтэт техник технологи ашиглан ажил гүйцэтгэх талаар санал ирүүлсэн оролцогч байхгүй байна.</p>	
2.3. Бараа худалдан авах тендерт 2015 оны 08 дугаар сарын 17 ны өдрийн Засгийн газрын 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллана.	<p>а) Монгол улсын Засгийн газрын 2015 оны 08 сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолын дагуу “2016 онд нийслэлийн хэмжээнд дотоодын үйлдвэрээс худалдан авсан бараа, бүтээгдэхүүний судалгаа”-г /9,7 тэрбум төгрөгийн 12 нэр төрлийн 703 ширхэг бараа бүтээгдэхүүн/ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагуудаас нэгтгэн 2017.02.20 өдрийн 01/120 дугаартай албан бичгээр Үйлдвэр хөдөө, аж ахуйн яаманд хүргүүлсэн.</p> <p>б) 2017 оны тайлант хугацаанд нийт ажлын 65,6 хувь буюу 216 төсөл, арга хэмжээний тендерийн урилга болон тендерийн баримт бичигт Засгийн газрын 336 дугаар тогтоолоор батлагдсан дотоодын үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахаар тусгасан. Үүний дүнд 9 багц ажилд 3,812,464,189 /гурван тэрбум найман зуун арван хоёр сая дөрвөн зуун жаран дөрвөн мянга нэг зуун наян ес/ төгрөгийн өртөг бүхий 95 нэр төрөл бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан.</p>	

<p>2.4. Худалдан авах ажиллагааны үр дүнг үнэлэх, гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлтийг боловсруулж нэвтрүүлнэ.</p>	<p>а) Худалдан авах ажиллагааны цахим систем шинээр нэвтрүүлж буйтай холбоотой систем ашиглалтын явцад гарч буй хүндрэл, бэрхшээл болон шийдвэрлэх, сайжруулах асуудлын талаар санал дүгнэлтийг гаргаж, Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны 1 дүгээр улирал болон эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны тайланд тусган, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2017.04.10 өдрийн 01/276 дугаар, 2017.07.06-ны өдрийн 01/1028 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>б) Тухайн онд хэрэгжүүлэхээр НИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт ба Нийслэлийн Засаг даргаас баталсан Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний биелэлт, явц, удаашралтай байгаа ажлын шалтгааныг судлан 2017.02.09 өдрийн 01/99 дугаар албан бичгээр, 2017.04.25 өдрийн 01/356 дугаар албан бичгээр, 2017.05.04 өдрийн 01/418 дугаарт албан бичгээр тус тус Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагад хүргүүлсэн.</p> <p>в) Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай захирамж гарсан өдрөөс үнэлгээний хороо байгуулах хүртэл дунджаар ажлын 2 өдөр, үнэлгээний хороо байгуулагдсан өдрөөс тендер зарлах хүртэл дунджаар ажлын 5 өдөр, тендер нээсэн өдрөөс захиалагчид гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлэх хүртэл ажлын 41 өдөр зарцуулж ажилласан байна.</p> <p>г) Тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой үүссэн гомдол ба түүний шийдвэрлэлийн үр дүнг худалдан авах ажиллагааны гол шалгуур үзүүлэлт болгон авч үзэж, худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор үнэлгээний хорооны нарийн бичгийн техникийн зөвлөгөөнийг тусгайлан хийж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нэг бүрээр заавар, зөвлөмж өгч, удирдлагаар хангаж байна.</p> <p>д) 2017.11.23 өдрийн 147 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтыг шаардлага хангасан нэг маягын бүртгэл хөтлөж хэвшүүлэх, цахим системийн ашиглалтыг сайжруулах, тендерийн үнэлгээг хууль журмын дагуу хийх асуудлаар заавар зөвлөмж өгөх, мөн хууль, журмын өөрчлөлттэй холбоотой мэдээллээр хангах сургалтыг төлөвлөж хөтөлбөр баталсан. Хөтөлбөрийн дагуу 2017 оны 12 сарын 01-ний өдөр Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтэс, Төрийн өмчийн</p>	
---	--	--

	<p>бодлого зохицуулалтын газар, Хамтын хөгжлийн мэргэшсэн институт зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Уг сургалтанд Нийслэлийн нутгийн захиргааны 18 байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны 9 албадын 78 албан хаагч хамрагдсан ба Сангийн яамны Хууль эрхзүйн хэлтсээс Төсвийн Ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны тайланд үндэслэн тухайн жилийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан танилцуулж, мэдээлэл хийсэн.</p>	
<p>2.5. Худалдан авах ажиллагааны чанар, үр дүнгийн талаар тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн сэтгэл хангамжийг тодорхойлох судалгаа зохион байгуулж ажиллана.</p>	<p>а) Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас санаачлан 2017 оны 02 дугаар сарын 20-ний өдөр зохион байгуулсан “Улаанбаатар худалдан авалт 2016” бизнес чуулга уулзалтын үеэр Засгийн газраас нэвтрүүлж буй цахим худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> системийн талаар болон Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a> цахим хуудсын талаар тендерт оролцогч аж ахуй нэгжийн 46 төлөөллөөс 6 асуулга бүхий бичил судалгаа авч, ажилласан.</p> <p>б) “Иргэний оролцоотой эрх зүйн жил”-ийн хүрээнд Засгийн газраас зохион байгуулсан 2017.05.15 өдрийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож, “Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүнг сайжруулах” талаар иргэд, олон нийтээс 8 асуулга бүхий судалгаа явуулж, санал хүсэлтийг тусгайлан бичгээр авч ажилласан. Судалгаанд 36 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон.</p> <p>в) 2017.10.26-ны өдөр зохион байгуулсан “Тендерт хэрхэн амжилттай оролцох” тухай сургалтын үеэр тендерт оролцогч 34 аж ахуйн нэгж, компанийн төлөөллөөс худалдан авах ажиллагааны чанар, үр дүнгийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг чөлөөт санал асуулга, анкетын хэлбэрээр авч ажилласан. Эдгээр судалгааны үр дүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тендерт хэт нарийн, олон төрлийн шалгуур үзүүлэлт тавьж өрсөлдөөнийг хязгаарлахаас сэргийлэх,</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу тендерт дотоодын давуу эрх тооцож байх.</li> <li>- Хамгийн бага үнээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нь хөрөнгө оруулалтын чанарт сөргөөр нөлөөлөх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.7.4 дэх заалтыг</li> </ul>	

	<p>шинэчлэх талаар хуулийн төсөл боловсруулж буй холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлэх,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Цахим тендерийн системийг боловсронгуй болгох,</li> <li>- Тендерийн үнэлгээг хийхдээ оролцогчдоос хууль, журамд нийцүүлэн нэмэлт тайлбар, тодруулга авч байх,</li> <li>- Нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх нөхцөл боломжийг дэмжиж ажиллах зэрэг асуудлыг 2017.05.22 өдрийн үнэлгээний хорооны нарийн бичгүүдийн хурлаар авч хэлэлцэн, хууль, журмын зохицуулалтын талаар болон цаашид анхаарах асуудлаар зөвлөмж, чиглэл өгч ажилласан.</li> </ul>	
<b>Зорилт 3: Төрийн захиргааны болон Хүний нөөцийн удирдлагын манлайллыг дээшлүүлж, менежментийн шинэлэг чиг хандлагыг нэвтрүүлнэ.</b>		
<p>3.1. Удирдлага, зохион байгуулалтын менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.</p>	<p>а) Байгууллагын үйл ажиллагааны менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын удирдлагыг хэрэгжүүлэхдээ дунд түвшний удирдагчийг идэвхижүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар хэлтэс, нэгжийн зохион байгуулалтыг хийсэн. Албан хаагчид харьяалан ажиллах хэлтсийн даргаас үүрэг чиглэл авч, ажил үүргийн биелэлтийг хангаж ажиллах ба хэлтсийн дарга нарт орлогч дарга, даргаас чиглэл заавар өгч, ажлын биелэлтийг хангуулах замаар удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний дүнд удирдах үйл ажиллагааны хурдыг сайжруулах нэгж албан хаагчийг богино хугацаанд үүрэгжүүлэх, дунд шатны удирдлагаас тухайн албан хаагчийн ажлын чанар, үр дүнг бодитоор үнэлэх, заавар чиглэл өгч сайжруулах, ажлын ачааллыг хуваарилах боломж, нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.</li> <li>- Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” журмыг 2017 оны 12 сарын 05-ны өдрийн А/145 тушаалаар батлан, нийт албан хаагчдад танилцуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. Үүний дүнд хэлтэс, нэгжүүдийн чиг үүргийн хэрэгжилт болон үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, үр дүнг стандартын дагуу тайлагнах, үнэлж дүгнэх аргачлалыг тодорхойлж ажилласан.</li> </ul>	



	<ul style="list-style-type: none"> <li>- Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу тус байгууллагаас авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017 оны 11 сарын 03-ны өдөр батлан, нийт албан хаагчдад танилцуулга хийж, биелэлтийг ханган ажиллаж байна.</li> </ul> <p>б) Худалдан авах ажиллагааны менежментийг сайжруулах, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол улсын Сангийн яамны 2017.05.23-ны өдрийн 176 дугаар албан бичгээр “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус Газрын дарга Э.Болормаа томилогдон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 8 дугаар сард багтаан боловсруулж, Сангийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна. Үүнтэй холбоотой тус газрын Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтэс, Хууль, хяналтын хэлтсээс “Аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын эрх, үүрэг”-ийг хуульчлах талаарх шаардлага, үндэслэлийг боловсруулж, 2017 оны 06 сарын 13-ны өдөр ажлын хэсэгт танилцуулж ажилласан.</li> <li>- Нийслэлд 2017 онд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохион байгуулалтыг эрчимжүүлэх талаар Нийслэлийн Засаг даргын 2017.06.05-ны өдрийн А/447 дугаар захирамжийг батлуулан, хэрэгжилтийг хангах талаар Нийслэлийн Агаарыг бохирдлыг бууруулах газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн Автозамын хөгжлийн газар, Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын удирдлагуудтай уулзалт хийж, хамтран ажилласан. Үүний дүнд захиалагч байгууллагаас 2017 оны 06 сарын 22 өдрийн дотор 14 төсөл, арга хэмжээний зураг, төсөв ажлын даалгаврыг ирүүлсэн ба худалдан авах ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.</li> <li>- 2017 онд зохион байгуулсан тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд анхаарч, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор цаашид анхаарах дараах асуудлаар</li> </ul>	
--	---	--

	<p>2017.10.30 өдөр нийт албан хаагчдад танилцуулга хийсэн. Үүнд: Тендерт хэт нарийн, олон төрлийн шалгуур үзүүлэлт тавьж өрсөлдөөнийг хязгаарлахаас сэргийлэх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн дагуу тендерт дотоодын давуу эрх тооцож байх, Хамгийн бага үнээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нь хөрөнгө оруулалтын чанарт сөргөөр нөлөөлөх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.7.4 дэх заалтыг шинэчлэх талаар хуулийн төсөл боловсруулж буй холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлэх, Цахим тендерийн системийг боловсронгуй болгох, Тендерийн үнэлгээг хийхдээ оролцогчдоос хууль, журамд нийцүүлэн нэмэлт тайлбар, тодруулга авч байх, Нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх нөхцөл боломжийг дэмжиж ажиллах.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тайлант хугацаанд тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яам, ШӨХТГ-т гарсан гомдлын судалгааг боловсруулан дүн шинжилгээ хийж ажилласан ба гомдол, маргаан гарах шалтгаан нөхцөлийг 2018 онд бууруулж ажиллах зорилт тавин ажиллаж байна.</li> <li>- Тендерийн баримт бичиг болон тендерт оролцогчоос ирүүлсэн саналын бүрэн бүтэн байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 онд 326 ширхэг лацыг ашиглаад байна.</li> </ul>	
<p>3.2. Байгууллагын 2017 оны төсвийн бүрдүүлэлт, хуваарилалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг сайжруулах, 2018 оны төсвийн хуваарилалтыг хийнэ.</p>	<p>а) Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоолоор тус байгууллагын 2017 оны төсвийн хязгаар 502,1 сая төгрөгөөр батлагдсан. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 сарын 18-ны өдрийн 10/13 тогтоолоор дээр батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.</p> <p>б) 2017 онд нийслэлийн төсвөөс тус байгууллагад 482,1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, 20,0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр төсөвлөгдсөн. 2017 оны 12 сарын 31 байдлаар 480,1 сая төгрөгийг зарцуулж, 22,0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Үндсэн үйл ажиллагаанаас олох жилийн орлогын төлөвлөгөөг 40,0 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан. 2016 оны жилийн</p>	

	<p>эцсийн тайлангаар Нийслэлийн төр захиргааны автобаазад 905,5 мянган төгрөгийн өглөгтэй байсныг төлж барагдуулсан. Мөн 2,550.6 мянган төгрөгийг үнэлгээний хорооны гишүүдэд олгохоор тооцож өглөгөөр бүртгэсэн байсныг аудитаар өгөгдсөн зөвлөмж, удирдлагын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу өглөгийг хааж, аудитын зөвлөмжийн биелэлтийг холбогдох газруудад хүргүүлж ажилласан.</p> <p>в) 2016 оны санхүүгийн тайлан, баримтууд нь Нийслэлийн Аудитын газраас аудитаар УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн зөрчилгүй санал дүгнэлтийг авсан.</p> <p>г) Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу “2016 оны жилийн санхүүгийн тайлан”-г 2017 оны 2 дугаар сарын 10-ны дотор, 2017 оны 1 дүгээр улирлын татварын тайлан гаргаж хуулийн хугацаанд нь Татварын Ерөнхий газарт цахим тайланг илгээсэн. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу 1,2,3,4,5-р саруудын НДШТайланг сар бүрийн 5-ний дотор харьяа дүүргийнхээ Нийгмийн даатгалын хэлтэст тушааж, цахим тайланг хугацаанд нь нийтлэсэн. 2017 оны 06 сарын 06-ны өдрийн байдлаар 26,8 сая төгрөгийн шимтгэл төлөлт хийгдсэн байна. Хүүхдээ харж байгаа 4 ажилтны шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон сар бүр тайланд тусгаж байна. Сар бүр хуулийн 5-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, НЗДТГ-ын СТСХ-т цаасаар хүргүүлж ажиллаж байна.</p> <p>д) НББОУС 1-санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС 2-бараа материал, НББОУС 7-мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх, НББОУС 16-үндсэн хөрөнгө, НББОУС 18-орлого, НББОУС 19 - ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн талаарх бүртгэлийн стандартуудыг гарын авлага болгон ашиглаж байна.</p> <p>е) Нийслэлийн өмчийн харилцааны газрын цахим системд байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, элэгдлийг тайланг оруулан, тулган баталгаажуулж санхүүгийн тайланд тусгасан эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж гэрээ хийсэн.</p> <p>ё) 2017 оны 1-12 сарын Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хөрөнгө мөнгөний зарцуулалтай холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш төгрөгийн гүйлгээ, аудитын газрын акт, тайлан, менежментийн захидал, аудитын гэрчилгээ зэргийг шилэн данс болон байгууллагын веб хуудсанд байршуулж олон нийтэд ил тод мэдээлсэн.</p>	
--	--	--

<p>3.3. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулж, ил тод мэдээлнэ.</p>	<p>а) Худалдан авах ажиллагааны хувьд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 48.5 дахь заалтын дагуу “2017 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-г Сангийн яамнаас батласан маягт 1-ийн дагуу батлуулан “Өдрийн сонин”-ы 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн №004/5570 дугаарт болон худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д 2017 оны 01 сарын 15-ны өдрийн дотор нийтлэж, олон нийтэд мэдээлсэн.</li> <li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргаас батласан “Худалдан авах ажиллагааны 2017 оны ерөнхий төлөвлөгөө”-нд тусгагдсан нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 444,131.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 106 багц хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг 2017.01.15 өдрийн дотор <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтлэж, олон нийтэд зарласан.</li> <li>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 25,683.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ болон нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 8,371,4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 285 багц төсөл, арга хэмжээг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нэмж тусган бүртгэн, иргэд олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн.</li> <li>- Тайлант хугацаанд 230 удаагийн тендерийн урилга, зарыг өдөр тутмын сонинд зарлан мэдээлсэн. Үүнд, эхний улиралд “Өдрийн сонин”-д 38, “УВ пост” сонинд 11 удаа тендерийн урилга, зар нийтлүүлсэн. 2017 оны 2 дугаар улирлаас өдөр тутмын сонинтой хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж, “Засгийн газрын мэдээ” сонинд 52, “Улс төрийн тойм” сонинд 47, “Монголын мэдээ” сонинд 64, “Өнөөдөр” сонинд 18 удаагийн тендерийн урилга, зар нийтлээд байна.</li> <li>- Худалдан авах ажиллагааны сар тутмын явцын мэдээлэл болон улирлын тайлан мөн худалдан авах ажиллагаанд хийсэн Аудитын дүгнэлт, зөвлөмжийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a> –д тухай бүр нийтлэн, ил тод нээлттэй мэдээлж байна.</li> </ul>	
--	---	--

	<ul style="list-style-type: none"> <li>- Тус газарт хэрэгжиж буй 52,678.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий бүхий 327 төсөл, арга хэмжээний тендерийн үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>, цахим систем болон байгууллагын цахим хуудас <a href="http://tender.ub-procurement.mn/">http://tender.ub-procurement.mn/</a>, <a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a>-д нийтлэн, ил тод мэдээлээд байна.</li> <li>б) Байгууллагын үйл ажиллагааны хувьд: <ul style="list-style-type: none"> <li>- 2017 оны 02 сарын 20 өдрийн “Улаанбаатар хөрөнгө оруулалт” бизнес чуулга уулзалтын үеэр “Худалдан авах ажиллагааны ил тод байдал” сэдвээр илтгэл тавьж, нийт оролцогч аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэсэн. Мөн уг өдөрлөгийн оролцогчдод тараагдсан “Монголиа экономи” сэтгүүлийн тусгай дугаарт нийтлэл өгч, хамтран ажилласан.</li> <li>- Өдрийн сонин”-ы 2017 оны 2 сарын 27-ны өдрийн дугаарт дарга Э.Болормаа Нийслэлд 2017 онд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны талаар ярилцлага нийтлүүлж, хамтран ажилласан.</li> <li>- Засгийн газар, нийслэлээс хэрэгжүүлж буй үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2017 оны 05 сарын 15-ны өдрийн 10-17 цагийн хооронд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож, тендерт оролцогч 23 аж ахуйн нэгж болон 11 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Энэ үеэр “Монгол” телевиз, “Эх орон” телевиз, MNC телевиз, ТМ телевиз, UBS телевиз, TV5 телевиз, Монголын радио, Үндэсний шуудан сонинтой тус тус хамтран ажиллаж, худалдан авах ажиллагааны талаар төрөөс баримтлаж буй бодлого, шинээр нэвтрүүлсэн ажил болон 2017 онд нийслэл хотод хэрэгжиж буй худалдан авалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан.</li> <li>- “Засгийн газрын мэдээ”-ы 2017 оны 2 сарын 27-ны өдрийн дугаарт дарга Э.Болормаа худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны онцлог, цахим систем болон салбарын бодлого шийдвэрийн талаар ярилцлага нийтлүүлж, хамтран ажилласан.</li> <li>- “Шилэн дансны тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, 2017 оны А/124 тушаалаар батлагдсан “Мэдээлэл, технологийн аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах тухай” журмын дагуу 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, тушаал, хүний нөөцийн болон төсөв, санхүү, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, журам</li> </ul> </li> </ul>	
--	--	--

	<p>жишиг бичиг баримтийн мэдээллийг хууль, журамд нийцүүлэн ил тод, нээлттэй хэлбэрээр байршуулан ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сошиал сүлжээнд ажлын үр дүн, үйл ажиллагааны талаар 8 удаагийн мэдээ мэдээллийг нийтлэж олон нийтэд сурталчилсан.</li> <li>- Тус газрын удирдлагууд 2017 оны 12 дугаар сарын 07-ны байдлаар 141 иргэн, 177 байгууллагын төлөөлөл, нийтдээ 318 иргэд болон байгууллагын төлөөллийг хүлээн авч уулзан, хууль,журмын дагуу үйл ажллагааны тааларх мэдээллийг өгч ажилласан.</li> <li>- 2017 оны 04 сард Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол Баянзүрх дүүргийн иргэдтэй хийсэн уулзалтад Газрын дарга Э.Болормаа, Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсийн дарга Б.Түмэнжаргал нар оролцож, тус дүүрэгт 2017 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, биелэлтийн явцыг танилцуулах, мэдээлэл өгч хамтран ажиллав. Уулзалтын үеэр тус дүүргийн 8 дугаар хорооны иргэн М.Энхбаярын хүсэлтээр “Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хорооны нутаг дэвсгэр гэр хорооллын дахин төлөвлөлтийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг Улаанхуаран дэд станцаас 5 мВт цахилгаан хэрэглээг хангах кабель шугам татах ажил”-ын явц болоод төсөв хөрөнгийн шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.</li> <li>- 2017 оны 03 сар, 05 дугаар сард Нийслэлийн Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалтад Газрын дарга Э.Болормаа, Орлогч дарга Б.Гүндсамбуу нар оролцож, нийслэлд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт ба зохион байгуулалт, биелэлтийн явцыг танилцуулж, иргэдийн хүсэлтээр дүүрэг, хороодод хэрэгжиж буй зарим ажлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч хамтран ажиллав. Уулзалтын үеэр Сүхбаатар дүүргийн гэр хороололд оршин суугч иргэдийг төлөөлж иргэн Н.Батбаяр “гэр хорооллын доторх гудамж, зам талбайн тохижилт, сул шороо болон гэрэлтүүлэгтэй холбоотой энэ онд хийгдэх ажлын талаар” мэдээлэл хүссэн. Газрын дарга Э.Болормаа Сүхбаатар дүүргийн төсвийн хөрөнгөөр энэ онд 5, 7, 10, 12, 15, 17, 18, 20 дугаар хороодод тохижилтын ажил хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл хийсэн.</li> </ul>	
--	---	--

	<p>- 2017 оны 11 сард Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд иргэдтэй уулзалтад Газрын дарга Э.Болормаа оролцсон бөгөөд Чингэлтэй дүүргийн иргэн Б.Жадамбаагийн хүсэлт болох үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ төрөх эмнэлгүүдэд худалдаалах цэг байгуулах асуудлыг шийдэж “Амгалан” амаржих газарт худалдаа эрхлэх боломжтой гэсэн хариуг өгсөн байна.</p>	
<p>3.4. Албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургаж хөгжүүлэх, үйл ажиллагаа мэргэжлийн түвшинг үнэлж, дүгнэнэ.</p>	<p>а) Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн магистрын ангид элсэн суралцаж буй 1 албан хаагчийн хүсэлтээр долоо хоног тутмын пүрэв гарагт цалинтай чөлөө олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>б) Удирдлагын академи болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үүрэг чиглэл болгосны дагуу Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн магистрын гарагийн сургалтанд 1 албан хаагч, менежерийн сургалтанд 2 албан хаагчийг тус тус тодорхойлон 2017.03. 25 өдөр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>в) Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 2 хэлтсийн дарга, 15 албан хаагчийг тус тус хамруулан, мэдлэг мэдээллийг дээшлүүлж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Авлигатай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан 2017.01.17 өдрөөс 18-ны өдрийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “ХАСХОМ”-ын сургалтанд Хууль, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар БНОУХ хамтран 2017.02.08-ны өдөр зохион байгуулсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагын чадавхийг бэхжүүлэх” сургалтад Хууль, хяналтын хэлтсийн дарга,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтсээс зохион байгуулсан 2017.03.28-ны өдрийн “Иргэний оролцоотой эрх зүйн шинжтгэлийн жил” сургалтад Хууль, хяналтын хэлтсийн дарга,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Гадаад харилцааны яамны консулын газартай хамтран Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулан 2017.03.29 өдөр зохион байгуулсан “Виз болон гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах тухай журам” сэдэвт сургалтанд Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн,</li> </ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Гэр бүл хөгжлийн газар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын хамтран 2017.04.21-ний өдөр зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль” сэдэвт сургалтад Хууль, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн нар,</li> <li>- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Батлан хамгаалахын их сургууль, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрууд хамтран 2017.04.28-ны өдөр зохион байгуулсан “Мэдээллийн аюулгүй байдлын тухай GOVSEC” сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн нар,</li> <li>- Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яамтай хамран Нийслэлийн үйлдвэрлэл инновацийн газраас зохион байгуулсан “Монголын инновацийн долоо хоног” 2017.05.08.-14 өдрүүдэд зохион байгуулагдсан сургалт семинарт 5 мэргэжилтэн,</li> <li>- Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс зохион байгуулсан Дотоод хяналт, шалгалт аудитын мэргэшүүлэх сургалтад Тогтоол захирамж, шийдвэрийн биелэлт, гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Удирдлагын академи хамтран 2017.06.14 өдөр зохион байгуулсан “Төрийн захиргааны бодлого төлөвлөлт” сэдэвт сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, Төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн,</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс 2017.12.04 өдөр зохион байгуулсан Төрийн захиргааны байгуулагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, Төсвийн захирагч нарын үр дүнгийн гэрээний илтгэх хуудсын стандартын талаарх сургалтад Орлогч дарга, Төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн,</li> </ul> <p>г) 2017 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг 2017.02.24-ний өдрийн А/34 дүгээр тушаалын хавсралтаар баталсан ба уг төлөвлөгөөний хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1 дүгээр сард “Хуулийн амин сүнс юу вэ?” сэдэвт сургалтыг 2017.01.25 өдөр,</li> </ul>	
--	--	--



	<ul style="list-style-type: none"> <li>- 2 дугаар сард Нийслэлийн Архивын газартай хамтран “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтыг 2017.02.03 өдөр, “Харилцааны соёл” сэдэвт сургалтыг 2017.02.14 өдөр,</li> <li>- 3 дугаар сард Сангийн яамтай хамтран “Тогтвортой худалдан авалт” сэдэвт сургалтыг 2017.03.31 өдөр,</li> <li>- 5 дугаар сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтэстэй хамтран “Захиргааны ерөнхий хууль”, сэдэвт сургалтыг 2017.05.25 өдөр, Нийслэлийн Залуучууд хөгжлийн газартай хамтран “Эерэг сэтгэлгээний давалгаа” сэдэвт сургалтыг 2017.05.26 өдөр,</li> <li>- 6 дугаар сард Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газартай хамтран “Агаар орчны бохирдол, хувь хүний нөлөө” сэдэвт сургалтыг 2017.06.12 өдөр,</li> <li>- 9 дүгээр сард “Ажил амьдралын баланс” сэдэв сургалт,</li> <li>- 10 дугаар сард Албан хэрэг хөтлөлтийн цахим системийн ашиглалтад гарах зөрчлийг бууруулах зорилгоор хариутай бичгийн шийдвэрлэлтийг оновчтой хийх, бичиг шилжүүлэхэд анхаарах асуудлын талаар 2017.10. 19-ний өдөр, “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын мөн чанар, хор уршиг, авлига ашиг сонирхлын зөрчил, Төрийн байгууллагын ил тод байдал” сэдэвт сургалтыг 2017.10.03-ний өдөр,</li> <li>- 11 дүгээр сард “Ёс зүй гэж юу вэ?, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, дүрмийн талаарх танилцуулах” сургалтыг 2017.11.03-ний өдөр, “Монгол улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн 01 дугаартай Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгавар, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас баталсан төлөвлөгөө болон НХААГ-ын төлөвлөгөөг танилцуулах” мэдээлэл сургалтыг 2017.11.21-ний өдөр, “Авлигатай тэмцэх газрын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт,</li> </ul>	
--	--	--

	<p>мөн хуулийн 16 дугаар зүйл “Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт” сэдэвт сургалтыг 2017.11.29-ний өдөр,</p> <ul style="list-style-type: none"> <li>- 12 дугаар сард Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш С.Гүндэгмааг урьж “Төрийн албан хаагчийн харилцааны болон биеэ авч явах соёл” сэдэвт сургалтыг 2017.12.01-ний өдөр тус тус нийт албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж өгсөн.</li> </ul>	
<p>3.5. Авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлж, төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг өндөржүүлэн, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.</p>	<p>а) <u>Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүтэц, орон тооны өөрчлөлттэй холбоотой Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, А/127 дугаар тушаалаар батлан, хууль журмын дагуу үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.</li> <li>- 2017.01.19-ний өдрийн А/06 тоот тушаалаар “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулсан.</li> <li>- “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, ажлын байранд хориглох зүйл, Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа албан хаагчдад хориглох зүйлсийг нарийвчлан зааж 2017.02.20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан.</li> <li>- Давхар ажил эрхлэлтийн тухай хууль, журмын мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан, албан хаагчдад мэдээлэл өгөх, нийтийн албанд томилогдож буй албан хаагчдыг хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил үүрэг гүйцэтгэж буй эсэхтэй танилцан, шийдвэрлэж ажилласан.</li> <li>- Эрх бүхий албан тушаалтан шинэчлэгдсэн бүтцийн дагуу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах хуулийн үйлчлэлд хамаарах 9 албан хаагчдад ХАСХОМ мэдүүлэх талаар сургалтыг 2017 оны 01-р сарын 19-ний өдөр зохион байгуулсан.</li> <li>- Хуулийн дагуу 2017 онд нийт давхардсан тоогоор 14 албан хаагч шинэчлэн буюу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг цахимаар мэдүүлж, цахимаар мэдүүлсэн мэдүүлгээ баталгааны маягтаар баталгаажуулан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.02.15-ны өдрийн 04/640 дугаартай “Тайлан ирүүлэх тухай” албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх газраас батлан хэрэгжүүлж байгаа дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож, ХАСХОМ-1,</li> </ul>	

	<p>ХАСХОМ-2 тайланг мэдүүлгийн системтэй уялдуулан үнэн зөв гаргаж 2017.02.23-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>- Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалаар батлагдсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын 4.2-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтан албан хаагчдын 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.01.12-ны өдрийн 04/160 дугаартай “ХАСХОМ-ийг баталгааны маягтаар бүртгэж авах тухай” албан бичгийн дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолд орсон нэмэлт өөрчлөлт буюу уг тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан 3 төрлийн баталгааны маягтыг өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>- Үнэлгээний хорооны гишүүд 473 удаад “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаж ажилласан ба уг мэдэгдлийг “shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.</p> <p>- Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 оны 10-р сарын 03-ны өдөр тус газрын нийт албан хаагчдад “Авлигын мөн чанар, шалтгаан хор хөнөөл, авлига ашиг сонирхлын зөрчил, байгууллагын ил тод байдлыг хэрхэн хангах талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>- 2017.11.29–ний өдөр АТГ-ын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 2017 оны 04-р сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт”, мөн хуулийн 16-р зүйл бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт сэдэвт сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан.</p> <p>- Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт батлах тухай А/139 дугаар тушаалыг 2017.11.20 өдөр батлан байгууллагын нийт албан хаагчдаас “Нууцын баталгаа”-г</p>	
--	---	--

	<p>гаргуулж ажилласан. Уг журмын 1 дүгээр хавсралтаар Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт, 2 дугаар хавсралтаар Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтныг зааж өгч ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан.</p> <p>- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018.01.15-ны дотор, 2017 оны ХАСХОМ-ын тайланг 2018.02.01-ний дотор НЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>- Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, хар жагсаалт гарган Сангийн яаманд бүртгүүлэх, дахин тендер шалгаруултад оролцуулахгүй байх арга хэмжээний хүрээнд тендерийн баримт бичгийг хуурамаар бүрдүүлж ирүүлсэн Үүний дүнд “Хансуун зам” ХХК, “Пи Си Эф” ХХК, “Биндэгноров” ХХК, “Тас Хайрхан” ХХК-уудыг хар жагсаалтад оруулахаар Сангийн яаманд 2017 оны 10 дугаар 13-ны өдрийн 02/1710 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Тендерийн баримт бичиг болон тендерт оролцогчоос ирүүлсэн саналын бүрэн бүтэн байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 онд 326 ширхэг лацыг ашиглаад байна.</p> <p>- Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг сугалааны зарчмаар санамсаргүй байдлаар сонгох аргыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>б) <u>Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг өндөржүүлэн Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах чиглэлээр:</u></p> <p>- Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу тус байгууллагаас авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017 оны 11 сарын 03-ны өдөр батлан, нийт албан хаагчдад танилцуулга хийж, биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>- Ёс зүйн зүйн зөрчлийн болон албан үүргээ биелүүлэхдээ иргэд үйлчлүүлэгчтэй эелдэг бус харьцаж, ялгаварлан гадуурхсан, хүнд суртал гаргасан талаарх зөрчлийг шалган тогтоох, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор гомдол, мэдээлэл хүлээн авах хаягийг <a href="http://ub-procurement.mn/">http://ub-procurement.mn/</a> цахим сайтад нээлттэй байршуулаад байна.</p>	
--	---	--

	<p>- 2017 оны А/127 дугаар тушаалаар Ёс зүйн хороог шинэчлэн, 5 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй байгуулсан. “Байгууллагын ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн ёс зүйн хорооны талаарх 3 заалт, албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх 2 заалт, албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх 6 зүйл бүхий нэмэлт өөрчлөлтийг хийж батласан. Ёс зүйн хороо нь 2017.11.03-нд “Ёс зүй гэж юу вэ?, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, дүрмийн талаарх танилцуулах” сургалт, 2017.11.21-ний өдөр “Монгол улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн 01 дугаартай Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгавар, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас баталсан төлөвлөгөө болон НХААГ-ын төлөвлөгөөг танилцуулах” мэдээлэл, 2017.11.29-ний өдөр “Авлигатай тэмцэх газрын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт, мөн хуулийн 16 дугаар зүйл “Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт” сэдэвт сургалт, 2017.12.01-нд Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш С.Гүндэгмаатай хамтран “Төрийн албан хаагчийн харилцааны болон биеэ авч явах соёл” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, төрийн албаны онцлог, үнэт зүйлс ба албан хаагчийн хувцаслалт, харилцааны онцлог, хариуцлага, яамлах ёс болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн талаарх хууль, дүрэм журмын талаар нийт албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж өгч хамтран ажилласан.</p> <p>- Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх ажлын хүрээнд ажилдаа хариуцлагагүй хандсан 2 албан хаагч, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага алдсан 2 албан хаагч болон нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан 5 албан хаагч нарт тус тус сануулах сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг авсан.</p> <p>- “Ажлын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт тавих тухай” журмыг шинэчлэн боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/131 тушаалаар батлуулсан. Уг ажлын хүрээнд 10 дугаар сарын ажлын цаг бүртгэл болон ажлын цаг ашиглалтын журмыг зөрчсөн 12 албан хаагчид анхааруулга өгсөн. Үүний дүнд 11 дүгээр сард албан</p>	
--	---	--

	<p>хаагчдын ирц, ажлын цагийн нягтрал сайжирч анхааруулга авсан албан хаагчдын тоо 50%-иар буурсан бөгөөд журмыг дахин зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцохоор төлөвлөн ажиллаж байна.</p> <p>- Хөрөнгө оруулалтын ажлын чанар үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахих чиглэлээр Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахих ажиллаж байгаа байгаа бөгөөд тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлээр 62,0 сая төгрөгийг хэмнэсэн байна. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө 18,0 сая төгрөгөөр батлагдсан ба тайлант хугацаанд тендерийн баримт бичгийн орлогоос 50,2 сая төгрөг олж орлогын төлөвлөгөөг 32,2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.</p> <p>- Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын биелэлтийг хангах 2017 оны 11 сарын 03-ны өдөр төлөвлөгөөний хэрэгжилтийг <a href="http://monitoring.ub.gov.mn">http://monitoring.ub.gov.mn</a> цахим систем нийтлэн, 2017 оны 11 сарын 10-ны өдрийн 01/1810 тоот албан бичгээр холбогдох газарт хүргүүлээд байна.</p>	
<p>3.6. Албан хаагчдын цалин хөлс, урамшууллыг ажлын үр дүнгээр олгох, шагнаж урамшуулах, тэтгэмж тэтгэлэгт хамруулах, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.</p>	<p>Хүний нөөцийн асуудлаар нийт 93 удаа Б тушаал батласан ба үүнээс албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшуулал, нийгмийн асуудлаар шийдвэрлэх асуудлаар буюу 9 удаагийн тушаал байна.</p> <p>-Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын чиглэл, зорилгыг 2017.02.24-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар баталж, биелэлтийг хангах ажиллаж байна. Үүнд,</p> <p>- Төрийн захиргааны 27 албан хаагчийн 2017 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийг хууль, журмын дагуу дүгнэж, “А” үнэлгээтэй төрийн захиргааны 15, төрийн үйлчилгээний 2 албан хаагчид үндсэн цалингийн 80%-иар, “В” үнэлгээтэй төрийн захиргааны 2 албан хаагчдад үндсэн цалингийн 60%-иар тус тус урамшуулал олгуулж ажилласан.</p> <p>- Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл цалин олгох тухай 1 удаагийн тушаал гаргаж, Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолын дагуу ажилласан.</p>	

<p>Зорилт-2: Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээ, тайланг хуулийн хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллана.</p> <p>а) Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын цахим хуудсын стандартын дагуу хөгжүүлэх, хууль, журамд заасан мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлнэ.</p> <p>б) Шилэн дансны <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a>, <a href="http://www.ub-procurement.mn">www.ub-procurement.mn</a> сайтад мэдээллийг тогтмол шинэчилж байршуулна.</p>	<p><b>Зорилт-2:</b></p> <p>а) - Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын цахим хуудсын стандартын дагуу хөгжүүлж, үндсэн загвар, дизайныг шинэчилж ажилласан. Цахим хуудсыг шинэчилснээр хайлтын системийн доголдлыг арилгах, үндсэн цэс болон дэд цэсний харагдах, ашиглах байдлыг ойлгомжтой болгосноос гадна 2017 оны А/124 тушаалаар батлагдсан “Мэдээлэл, технологийн аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлыг хангах тухай журмаар заасан мэдээ, мэдээллийг шинэчлэн нийтлэх ажил хийгдэж байна.</p> <p>б) - Шилэн дансны тухай хууль, “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг хангах арга хэмжээний хүрээнд “shilendans.gov.mn” цахим хуудаст жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас жилийн гүйцэтгэл, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, сар улирлын гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, хагас жилийн тайлан, аудитын тайлан, дүгнэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тендер шалгаруулалтын талаарх мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, орлого зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийн хамт байршуулан мэдээлж байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “2017 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-г Сангийн яамнаас баталсан маягт1-ийн дагуу нийтлэж, олон нийтэд мэдээлсэн.</li> <li>- Тус газарт нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын үр дүн буюу тендерт оролцогчийн шалгарсан, шалгараагүй үндэслэлийг тухай бүр нийтлэж байна. “Шилэн дансны тухай хууль”, “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”-ын дагуу 152,678.4 сая төгрөгийн</li> </ul>	
--	---	--

<p><b>Зорилт-3:</b> Худалдан авах ажиллагааны бүртгэл, тайлагналт хууль, журмын дагуу хэрэгжинэ.</p> <p>а) Нийслэлд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын мэдээллийг НЗДТГ, СЯ болон</p>	<p>батлагдсан төсөвт өртөг бүхий 327 төсөл, арга хэмжээний тендерийн үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системд нийтлэн, ил тод мэдээлээд байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2017.04.20 өдрийн А/13 тушаалаар батлагдсан “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-г мэдээлсэн.</li> <li>- Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлт, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, 2017 оны 1-12 сарын Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хөрөнгө мөнгөний зарцуулалтай холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш төгрөгийн гүйлгээ, аудитын газрын акт, тайлан, менежментийн захидал, аудитын гэрчилгээ зэргийг тухай бүрд нийтлэх мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол мэдээлэн ажиллаж байна.</li> <li>- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус бүр хуулийн хугацаанд багтаан мэдээлж байна.</li> <li>- Үнэлгээний хорооны гишүүд 473 удаад “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаж ажилласан ба уг мэдэгдлийг <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.</li> <li>- <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулан мэдээлэв.</li> </ul> <p><b>Зорилт-3:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1148 дугаар захирамжийн дагуу “Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайлан”-г нэгтгэн хүргүүлэх ажлын хүрээнд Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадаас зохион байгуулж буй 37,270.1 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 518 төсөл, арга хэмжээ, нийслэлийн нутгийн захиргааны 21 байгууллагад хэрэгжиж буй 273,603.4 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 284 төсөл арга хэмжээний мэдээллийг нэгтгэн ажиллаж байна.</li> </ul>	
--	---	--

<p>холбогдох газруудад цаг хугацаанд нь тайлагнана.</p>	<p>Үүнд: “2016 оны жилийн эцсийн тайлан”-г 2017.01.13 өдрийн 01/32 дугаартай албан бичгээр, 2017 оны 1-р сарын тайланг 2017.02.08 өдрийн 01/83 дугаартай албан бичгээр, 2017 оны 2-р сарын тайланг 2017.03.09 өдрийн 01/144 дугаартай албан бичгээр, 2017 оны 3-р сар буюу 1 дүгээр улирлын тайланг НХААГ-ийн 2017.04.10 өдрийн 01/276 дугаар албан бичгээр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.04.17 өдрийн 01/1348 дугаар албан бичгээр, 2017 оны 4-р сарын тайланг 2017.05.04 өдрийн 01/417 дугаар албан бичгээр, 2017 оны 5-р сарын тайланг 2017.06.04 өдрийн 01/719 дугаар албан бичгээр, 6-р сарын тайланг 2017.07.06-ны өдрийн 01/1028 дугаар албан бичгээр, 7-р сарын тайланг 2017.08.04 өдрийн 01/1254 дугаар албан бичгээр, 9-р сарын тайланг 2017.09.08 өдрийн 01/1506 дугаар албан бичгээр, 9-р сарын тайланг 2017.10.06 өдрийн 01/1656 дугаар албан бичгээр, 10-р сарын тайланг 2017.11.03 өдрийн 01/1794 дугаар албан бичгээр, 11-р сарын тайланг 2017.12.05 өдрийн 01/1911 дүгээр албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн Засаг дарга, НЗДТГ-ын холбогдох хэлтсүүдэд тус тус хүргүүлж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн Ерөнхийлөн захирагчаас 2016 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланд 9 дүүргийн худалдан авах ажиллагааны газарт хэрэгжсэн 502 төсөл, арга хэмжээ болон нийслэлийн нутгийн захиргааны 15 байгууллагад хэрэгжсэн 303 төсөл, арга хэмжээний худалдан авалтын тайланг нэгтгэн, 2017.01.13 өдрийн 01/32 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг дарга, Сангийн яаманд хүргүүлсэн.</li> <li>- Төсвийн Ерөнхийлөн захирагчаас 2017 оны эхний улиралд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг 2017.04.10 өдрийн НХААГ-ийн 01/276 дугаар албан бичгээр болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.04.17-ны өдрийн 01/1348 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг дарга, Сангийн яаманд хүргүүлсэн.</li> <li>- Төсвийн Ерөнхийлөн захирагчаас 2017 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг 2017.07.06-ны өдрийн 01/1028 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг дарга, Сангийн яаманд хүргүүлсэн.</li> <li>- Төсвийн Ерөнхийлөн захирагчаас 2017 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг 2017 оны 12 сарын 15-ны өдөрт Нийслэлийн Засаг даргад хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна.</li> </ul>	
---	--	--

	<p>- Нийслэлийн удирдлагыг худалдан авалтын мэдээллээр хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын А/887 захирамжийн биелэлтийн мэдээг 2017.02.09 өдрийн 01/99 дугаартай албан бичгээр, НИТХ-ын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 6/11 тогтоолоор батлагдсан худалдан авах ажиллагааны явцын мэдээг 2017.04.25 өдрийн 01/356 дугаартай албан бичгээр, Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй худалдан авах ажиллагааны явцын мэдээг 05 сарын 31 өдрийн байдлаар 2017.05.04 өдрийн 01/418 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p> <p>- Сангийн яаманд “Тендер шалгаруулалтад хийсэн хяналт шалгалтын дүгнэлт”-тэй холбоотой тайлбар мэдээллийг Нийслэлийн Засаг даргад 2017.09.08-ны өдрийн 01/1507 дугаар албан бичгээр хүргүүлж ажилласан.</p>	
<p><b>3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар:</b></p> <p><b>Зорилт-1:</b> Худалдан авах ажиллагааны газрын 2018 оны төсвийн төлөвлөлт, 2017 оны төсвийн хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих, хөрөнгийн ашиглалт, Үр өгөөжийг сайжруулах</p> <p>а) -Аудит, дотоод аудит хийгдсэн байх, хяналт тавьж ажилласан байх, Мэдээллийн ил тод байдлыг хангаж, “Шилэн дансны хууль”-ийг хэрэгжүүлж ажилласан байх.</p>	<p><b>Зорилт-1:</b></p> <p>-Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дүгээр тогтоолоор тус байгууллагын 2017 оны төсвийн хязгаар 502,1 сая төгрөгөөр батлагдсан. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2017 оны 05 сарын 18-ны өдрийн 10/13 тогтоолоор дээр батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна. 2017 онд нийслэлийн төсвөөс тус байгууллагад 482,1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,0 сая төгрөгөөр санхүүжихээр төсөвлөгдсөн. 2017 оны 12 сарын 31 байдлаар 480,1 сая төгрөгийг зарцуулж, 22,0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Үндсэн үйл ажиллагаанаас олох жилийн орлогын төлөвлөгөөг 40,0 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажилласан.</p> <p>- Нийслэлийн Аудитын газраас 2016 оны санхүүгийн тайлан, баримтад шалгалт хийж, “УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн зөрчилгүй” санал дүгнэлтийг 2017.03.07-ны өдөр ирүүлсэн. Уг аудитын зөвлөмж болон удирдлагын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн дагуу 2,550.6 мянган төгрөгийг үнэлгээний хорооны гишүүдэд олгохоор тооцож өглөгөөр бүртгэсэн байсан өглөгийг хааж, Нийслэлийн аудитын зөвлөмжийн биелэлтийг холбогдох газруудад 2017.06.06 өдөр хүргүүлж ажилласан.</p>	

<p><b>Зорилт-2:</b> Санхүүгийн тайлан, төсвийн мэдээлэл болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг ил тод мэдээлэх, хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах</p> <p>а) Нийслэлийн Аудитын газрын дүгнэлт болон санхүүгийн холбогдолтой мэдээллийг ил тод болгож, байгууллагын цахим хуудсанд байршуулах.</p>	<p>- “2016 оны Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт”-ийг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас дүгнэж, 2017.03.07-ны өдрийн 497 дугаар албан бичгээр 92 оноо авч “А” үнэлгээ ирүүлсэн.</p> <p>- <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> мэдээллийн нэгдсэн системд татаж авах, хэвлэх боломжтойгоор, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулан мэдээлэв. Үүнд: “2017 оны худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-г Сангийн яамнаас баталсан маягт1-ийн дагуу нийтлэж, олон нийтэд мэдээлсэн. Тус газарт нийслэлийн Засаг даргаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын үр дүн буюу тендерт оролцогчийн шалгарсан, шалгараагүй үндэслэлийг тухай бүр нийтлэж байна. Нийслэлийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2017.04.20 өдрийн А/13 тушаалаар батлагдсан “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-г мэдээлсэн. Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлт, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тухай бүрд нийтлэх мэдээллийг хуулийн хугацаанд тогтмол мэдээлэн ажиллаж байна.</p> <p><b>Зорилт-2:</b></p> <p>- Нийслэлийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2017.04.20 өдрийн А/13 тушаалаар батлагдсан “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”, Нийслэлийн Аудитын газраас 2017.03.07-ны өдөр ирүүлсэн 2016 оны санхүүгийн тайлан, баримтад шалгалт хийж, “УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн зөрчилгүй” санал дүгнэлт болон Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 2017.03.07-ны өдрийн 497 дугаар албан бичгээр ирүүлсэн “2016 оны Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт”-ийг тус тус шилэн дансны системд нийтлэж ажилласан.</p>	
<p><b>4.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар:</b></p>	<p><b>Зорилт-1:</b></p> <p>- Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017.07.02-ны өдрийн хурлын шийдвэр болон 2017.12.11 өдрийн А/146 дугаар тушаалаар батлагдсан комиссоос</p>	

<p><b>Зорилт-1:</b> Байгууллагын эд хөрөнгө ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллах, эмх цэгцтэй байлгах.</p> <p>а) Үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах.</p> <p>б) Эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг үнэн зөв хийх.</p>	<p>хөрөнгийн тооллогыг хагас жил болон жилийн эцсийн байдлаар 2 удаа зохион явуулсан ба 2017 оны байдлаар нийт 35 үндсэн албан хаагчийн эд хөрөнгө ашиглалтын карт хөтлөлтийг хийгээд байна.</p> <p>- Нийслэлийн өмчийн харилцааны газартай 2017.04.24-ний өдөр “Өмч эзэмшүүлэх гэрээ” байгуулан, 250 тоо ширхэг 61,493,083,44 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тоног төхөөрөмж, 374 тоо ширхэг 39,672,474.96 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тавилга, эд хогшил, 7 төрлийн 19,751,311.04 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий биет бус хөрөнгийг хуулийн дагуу эзэмшин ажиллаж байна.</p> <p>-“Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай” 2017.04.24 өдрийн А/64 дүгээр тушаалыг баталж, элэгдлээрээ өртөгөө нөхсөн 69 ширхэг, 15,711,610 төгрөгийн тоног төхөөрөмж, 4 ширхэг программ хангамж, элэгдлээрээ өртөгөө нөхөх боломжгүй 61 ширхэг 4,009,437 төгрөгийн үндсэн хөрөнгийг 2017.01.16-ны өдрийн А/06, 2017.02.01-ний өдрийн А/44, 2017.02.23-ны өдрийн А/69 дугаар тушаалын дагуу балансаас хасуулах, 14 нэр төрлийн 64 ширхэг 8,546,620.00 төгрөгийн илүүдэлтэй тавилга, эд хогшлийг Нийслэлийн Статистикийн газрын балансад шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулж ажилласан.</p> <p>-2016 оны Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/122 дугаар тушаалаар Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх хуудсаар 92 оноо буюу “А” үнэлгээ авч ажилласан.</p>	
<p><b>5.Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар:</b></p> <p><b>Зорилт-1:</b> Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулан батлаж, хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p><b>Зорилт-1:</b></p> <p>- Мэргэжлийн дагуу магистрын ангид элсэн суралцаж буй албан хаагчдын хүсэлтийг шийдвэрлэн, долоо хоног тутмын пүрэв гарагт цалинтай чөлөө олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>- Удирдлагын академи болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үүрэг чиглэл болгосны дагуу Удирдлагын академийн Төрийн захиргааны менежментийн магистрын гарагийн сургалтанд 1 албан хаагч, менежерийн сургалтанд 2 албан хаагчийг тус тус тодорхойлон 2017.03. 25 өдөр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагаас зохион байгуулсан 10 удаагийн сургалтад 2 хэлтсийн дарга, 15 албан хаагчийг тус тус хамруулан, 2 албан хаагчид “Компьютерийн анхан шатны хэрэглээний сургалт”, “Хяналт шалгалт,</p>	



<p>а) Мэргэжлийн дагуу сургалтад оролцох нөхцлийг хангах.</p> <p><b>Зорилт-2:</b> Ажлын байран дээр сургалт зохион байгуулах.</p> <p>а) Шинэ ажилтныг сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулах.</p>	<p>мониторингийн анхан шатны сургалт”-ын гэрчилгээ эзэмшүүлж мэргэжлийн дагуу сургалтад хамрагдах нөхцөл боломжийг ханган ажилласан.</p> <p><b>Зорилт-2:</b> 2017 онд хэрэгжүүлэх ажлын байранд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг 2017.02.24-ний өдрийн А/34 дүгээр тушаалын хавсралтаар баталсан ба уг төлөвлөгөөний хүрээнд тайлант хугацаанд 14 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1 дүгээр сард “Хуулийн амин сүнс юу вэ?” сэдэвт сургалтыг 2017.01.25 өдөр,</li> <li>- 2 дугаар сард Нийслэлийн Архивын газартай хамтран “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт сургалтыг 2017.02.03 өдөр, “Харилцааны соёл” сэдэвт сургалтыг 2017.02.14 өдөр,</li> <li>- 3 дугаар сард Сангийн яамтай хамтран “Тогтвортой худалдан авалт” сэдэвт сургалтыг 2017.03.31 өдөр,</li> <li>- 5 дугаар сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтэстэй хамтран “Захиргааны ерөнхий хууль”, сэдэвт сургалтыг 2017.05.25 өдөр, Нийслэлийн Залуучууд хөгжлийн газартай хамтран “Эерэг сэтгэлгээний давалгаа” сэдэвт сургалтыг 2017.05.26 өдөр,</li> <li>- 6 дугаар сард Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газартай хамтран “Агаар орчны бохирдол, хувь хүний нөлөө” сэдэвт сургалтыг 2017.06.12 өдөр,</li> <li>- 9 дүгээр сард “Ажил амьдралын баланс” сэдэвт сургалт,</li> <li>- 10 дугаар сард Албан хэрэг хөтлөлтийн цахим системийн ашиглалтад гарах зөрчлийг бууруулах зорилгоор хариутай бичгийн шийдвэрлэлтийг оновчтой хийх, бичиг шилжүүлэхэд анхаарах асуудлын талаар 2017.10. 19-ний өдөр, “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын мөн чанар, хор уршиг, авлига ашиг сонирхлын зөрчил, Төрийн байгууллагын ил тод байдал” сэдэвт сургалтыг 2017.10.03-ний өдөр,</li> <li>- 11 дүгээр сард “Ёс зүй гэж юу вэ?, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, дүрмийн талаарх танилцуулах” сургалтыг 2017.11.03-ний өдөр, “Монгол улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн 01 дугаартай Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгавар, түүний дагуу</li> </ul>	
---	--	--

	<p>Нийслэлийн Засаг даргаас баталсан төлөвлөгөө болон НХААГ-ын төлөвлөгөөг танилцуулах” мэдээлэл сургалтыг 2017.11.21-ний өдөр, “Авлигатай тэмцэх газрын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт, мөн хуулийн 16 дугаар зүйл “Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт” сэдэвт сургалтыг 2017.11.29-ний өдөр,</p> <ul style="list-style-type: none"> <li>- 12 дугаар сард Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш С.Гүндэгмаг урьж “Төрийн албан хаагчийн харилцааны болон биеэ авч явах соёл” сэдэвт сургалтыг 2017.12.01-ний өдөр тус тус нийт албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж өгсөн.</li> </ul>	
<b>Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО</b>		30

**ДӨРӨВ: МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ БИЕЛЭЛТ:**

<p><b>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</b></p>	<p><b>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</b></p>	<p><b>Төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</b></p>
<p><b>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт-1:</b> Худалдан авах үйл ажиллагаанд тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлон, оновчтой арга хэмжээ авч ажиллах. а) Холбогдох шинэ хууль, тогтоомж, журмуудийг судлан, хууль, журмын өөрчлөлтөд санал хүргүүлнэ.</p>	<p>а) Холбогдох шинэ хууль, тогтоомж, журмуудийг судлан, хууль, журмын өөрчлөлтөд санал хүргүүлэх ажлын хүрээнд: - Газрын дарга Э.Болормаа нь Монгол Улсын Их сургуулийн Хуулийн сургуульд докторантурт суралцаж байна. - Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан “Олон улсын журмаар зохион байгуулах худалдан авах ажиллагаа” сэдэвт 2 өдрийн сургалтад 2017.04.04-нөөс 2017.04.05-ны өдрүүдэд хамрагдсан. Монгол улсын Сангийн яамны 2017.05.23-ны өдрийн 176 дугаар албан бичгээр “Засгийн газрын худалдан авах ажиллагааг бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус Газрын дарга Э.Болормаа томилогдон, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2017 оны 8 дугаар сард багтаан боловсруулж, Сангийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлдэн ажиллаж байна. Үүнтэй холбоотой тус газрын Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтэс, Хууль, хяналтын хэлтсээс “Аймаг, нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын эрх, үүрэг”-ийг хуульчлах талаарх шаардлага, үндэслэлийг боловсруулж, 2017 оны 06 сарын 13-ны өдөр ажлын хэсэгт танилцуулж ажилласан.</p>	

<p>б) 2016 онд үнэлгээний хороо байгуулах ажлын дундаж хугацаа 7 хоног, тендерийн иж бүрдэл, бэлтгэл хангах хугацаа 12 хоног, тендерийн үнэлгээний дундаж хугацаа 17 хоног байсан. Эдгээр хугацааг тус бүр 1 хоногоор багасгаж ажиллана.</p>	<p>- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг салбарын албан хаагчид болон тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж, хэлэлцүүлгийн дүн, саналыг нэгтгэн 2017 оны 09 сарын 19-ний өдрийн 02/1573 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Уг хэлэлцүүлэг нь тус байгууллагын болон Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын дарга, ахлах мэргэжилтнүүдийг хамруулан 2017.09.05-ны өдөр, тендерт оролцогч 32 аж ахуйн нэгжийг хамруулан 2017.09.06-ны өдөр тус тус зохион байгуулагдсан.</p> <p>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон тендерийн жишиг баримт бичигт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 02/1758 дугаар албан бичгээр Монгол улсын Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг 2017 оны 11 сарын 11-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн.</p> <p>б) - Худалдан авах ажиллагаанд зарцуулсан хугацааг тооцож үзвэл Нийслэлийн Засаг даргаас худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай захирамж гарснаас үнэлгээний хороо байгуулах хүртэл дунджаар ажлын 2 өдөр, үнэлгээний хороо байгуулагдсан өдрөөс тендер зарлах хүртэл дунджаар ажлын 5 өдөр, тендер нээсэн өдрөөс захиалагчид гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлэх хүртэл дунджаар ажлын 41 өдөр, худалдан авах ажиллагааны</p>	
--	---	--

	<p>зохион байгуулалтад дунджаар ажлын 28-57 өдрийг зарцуулж ажилласан байна. Төлөвлөсөн хугацаатай харьцуулбал, үнэлгээний хороо байгуулах ажлын дундаж хугацааг 4 өдөр, тендерийн иж бүрдэл, бэлтгэл хангах хугацаа 6 хоногоор эрчимжүүлж ажилласан боловч тендерийн үнэлгээний хугацааг 28 хоногоор удаашруулсан байна. Цаашид тендерийн үнэлгээний дундаж хугацааг бууруулахаар зорилт тавин ажиллаж байна.</p>	
<p><b>Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт -2:</b> Худалдан авах ажиллагаанд шинэ санаа, шилдэг арга туршлагыг судлан хэрэгжүүлэх.</p> <p>а) Худалдан авах ажиллагааны чиглэлээр олон улсын байгууллагын сайн туршлагыг судлах зорилгоор туршлага солилцох уулзалт, ярилцлагыг зохион байгуулна.</p>	<p>а)</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тайлант хугацаанд Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй 15 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг олон улсын журмаар зохион байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд тендерийн баримт бичиг дээр ажиллах, урилга зар нийтлэх, тендерийн нээлтийг зохион байгуулах, оролцогчдоос ирүүлсэн саналыг үнэлэх, үнэлгээний хорооны хуралд оролцох, тайлан бичих зэрэгт олон улсад өргөн хэрэглэгддэг хэл буюу англи хэлийг ашиглаж, олон улсын журам болон жишиг бичиг баримтыг судлаж, ашиглахын дээр худалдан авах ажиллагаанд санал ирүүлсэн оролцогчийн эрх ашгийг хамгаалж хувилбарт санал ирүүлэхийг зөвшөөрөх, үнэлгээнд олон талын тодруулга ашиглах зэрэг сайн туршлагаас хуваалцан ажиллаж байна.</li> <li>- Худалдан авах ажиллагааг олон улсын журмаар зохион байгуулахад хамтран ажиллаж буй олон улсын байгууллагаас зохион байгуулсан дараах сургалтуудад хамрагдан, мэдлэг чадвараа дээшлүүлж байна. Үүнд, <ul style="list-style-type: none"> <li>○ Сангийн яамны Хууль Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй хамтран 2017.03.31 өдөр “Тогтвортой худалдан авалт” сэдэвт сургалт зохион байгуулж, 9 Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын 19 мэргэжилтэнийг хамруулсан.</li> </ul> </li> </ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>○ “Орлогод нийцсэн орон сууц” төслийн нэгжээс 2017 оны 4 дүгээр сард зохион байгуулсан Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн танилцуулгын сургалтад Худалдан авах ажиллагаа зохион байгуулах хэлтсээс олон улсын журмаар зохион байгуулах худалдан авах ажиллагааг хариуцаж буй 2 албан хаагч хамруулсан.</li> <li>○ Азийн хөгжлийн банкны олон улсын зөвлөхүүдийн багаас 2017 оны 4 дүгээр сард хүний нөөцийн чадавхийн үнэлгээ хийх, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр нэгжээс эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг олон улсын журмаар хэрхэн зохион байгуулах, ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд албан хаагчдыг хэрхэн чадавхижуулах талаар хэлэлцсэн.</li> <li>○ 2017.06.20 өдөр Нийслэлийн орон сууц корпорацийн төлөөлөл олон улсын журмаар зохион байгуулагдах төсөл, арга хэмжээг хариуцан ажиллаж буй мэргэжилтнүүдийн чадавхийг үнэлэх уулзалт, судалгаа зохион байгуулсан.</li> <li>○ 2017.06.23 өдөр Улаанбаатар гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн нэгжээс “Олон улсын журмаар зохион байгуулж буй тендерийн нээлтийг хэрхэн зохион байгуулах” талаар сургалт зохион байгуулж, зөвлөмж өгсөн.</li> <li>○ 2017.06.27 өдөр Улаанбаатар хот гэр хорооллын төслийн нэгжийн удирдагч Авирмэд, зөвлөх Лакомб нар “Азийн хөгжлийн банкны журмаар зохион байгуулсан тендерийн үнэлгээний тайлан”-г хэрхэн бичих талаар зөвлөмж, заавар өгсөн.</li> </ul>	
--	---	--

**ТАВ. НЭМЭЛТЭЭР ҮҮРЭГ БОЛГОСОН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:**

<p><b>Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</b></p>	<p><b>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</b></p>	<p><b>Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-40 оноо)</b></p>
<p>1</p>	<p>2</p>	<p>3</p>
<p>1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2017 оны “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил болгон зарлах тухай” А/01 дугаартай захирамжийн биелэлтийг хангах.</p>	<p>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 05 дугаар сард зохион байгуулсан “Эрх зүйн шинэтгэлийн жил” сэдэвт нээлттэй өдөрлөгт оролцож, 2017.05.13-ны өдөр “Худалдан авах ажиллагаа” сэдэвт нээлттэй өдөрлөгийг Сүхбаатарын талбайд зохион байгуулж ажилласан. Худалдан авах ажиллагааны чанар ба тэгш өрсөлдөөн” сэдэвт хэлэлцүүлэг хийж, иргэдэд хуулийн зөвлөгөө өгч, худалдан авах ажиллагааны талаарх төрөөс баримталж буй бодлого, шинээр хэрэгжүүлж буй ажил, салбарын үйл ажиллагаа, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэх өгөх, мөн 2017 онд нийслэл хотод хэрэгжиж буй худалдан авалтын талаар олон нийт, тендер сонирхогч аж ахуйн нэгж, иргэдийг мэдээллээр хангах чиглэлээр ажилласан. Мөн уг арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн байгууллагыг урьж 6 телевиз, 1 өдөр тутмын сонин, 1 радиогоор иргэд олон нийтэд мэлээл хүргэсэн.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.01.02-ны өдрийн 04/03 дугаартай албан бичгийн дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2017 оны “Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жил болгон зарлах тухай” А/01 дугаартай</p>	

	<p>захирамжийн хүрээнд 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах саналыг 2017.01.05-ны өдрийн 03/11 дугаартай албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.</p> <p>- Эрх зүйн шинэтгэлийн жилийн хүрээнд худалдан авах ажиллагаатай холбоотой гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран ажиллаж, 2017 оны 12 сарын 6-8 өдрүүдэд “Худалдан авах ажиллагааны хууль журам ба тендертэй холбоотой үүсч буй гэмт хэргийг ангилах нь” сэдэвт илтгэлийг тавьж, мэдээлэл хийсэн.</p> <p>- Эрх зүйн ажлын тайланг 2017.06.16-ны өдрийн 03/827 дугаартай албан бичиг, 2017.12.08-ны өдрийн 03/1925 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын ХЭЗХ-т тус тус хүргүүлсэн.</p> <p>- Газрын хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 5 гомдол, 49 хүсэлт ирж хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байна. Үүнээс тендер оролцогч аж ахуйн нэгжээс ирүүлсэн гомдол, саналыг судлаж, ил тод, нээлттэй байдлыг хуулийн хүрээнд дээшлүүлж худалдан авах ажиллагааны цахим систем, байгууллагын цахим хуудсыг мэдээллийг тогтмол шинэчлэх талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажилласан.</p>	
<p>1.2 Монгол улсын Засгийн газрын 2017 оны 10 сарын 26-ны өдрийн 01 дугаартай “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын хэрэгжилтийг хангах.</p>	<p>а) Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу тус байгууллагаас авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2017 оны 11 сарын 03-ны өдөр батлан, нийт албан хаагчдад танилцуулга хийж, биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>- Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор 2017 оны 10 сард Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, А/127 дугаар тушаалаар батлан, хууль журмын дагуу үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>- Ёс зүйн зүйн зөрчлийн болон албан үүргээ биелүүлэхдээ иргэд үйлчлүүлэгчтэй эелдэг бус харьцаж, ялгаварлан гадуурхсан, хүнд суртал гаргасан талаарх зөрчлийг шалган тогтоох, төрийн байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор гомдол, мэдээлэл</p>	



	<p>хүлээн авах хаягийг <a href="http://ub-procurement.mn/">http://ub-procurement.mn/</a> цахим сайтад нээлттэй байршуулаад байна.</p> <p>- “Байгууллагын ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн ёс зүйн хорооны талаарх 3 заалт, албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх 2 заалт, албан хаагчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх 6 зүйл бүхий нэмэлт өөрчлөлтийг хийж батласан.</p> <p>- Ёс зүйн хороо нь 2017.11.03-нд “Ёс зүй гэж юу вэ?, Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал, дүрмийн талаарх танилцуулах” сургалт, 2017.11.21-ний өдөр “Монгол улсын Засгийн газрын 2017.10.26-ны өдрийн 01 дугаартай Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгавар, түүний дагуу Нийслэлийн Засаг даргаас баталсан төлөвлөгөө болон НХААГ-ын төлөвлөгөөг танилцуулах” мэдээлэл, 2017.11.29-ний өдөр “Авлигатай тэмцэх газрын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 2017 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт “Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт, мөн хуулийн 16 дугаар зүйл “Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт” сэдэвт сургалт, 2017.12.01-нд Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш С.Гүндэгмаатай хамтран “Төрийн албан хаагчийн харилцааны болон биеэ авч явах соёл” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж, төрийн албаны онцлог, үнэт зүйлс ба албан хаагчийн хувцаслалт, харилцааны онцлог, хариуцлага, яамлах ёс болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн талаарх хууль, дүрэм журмын талаар нийт албан хаагчдад мэдээлэл, зөвлөмж өгч хамтран ажилласан.</p> <p>- Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх ажлын хүрээнд ажилдаа хариуцлагагүй хандсан 2 албан хаагч, ажлын цаг ашиглалт, сахилга хариуцлага алдсан 2 албан хаагч болон</p>	
--	---	--

	<p>нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан 5 албан хаагч нарт тус тус сануулах сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээг авсан.</p> <p>- “Ажлын цаг бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт тавих тухай” журмыг шинэчлэн боловсруулж 2017 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/131 тушаалаар батлуулсан. Уг ажлын хүрээнд 10 дугаар сарын ажлын цаг бүртгэл болон ажлын цаг ашиглалтын журмыг зөрчсөн 12 албан хаагчид анхааруулга өгсөн. Үүний дүнд 11 дүгээр сард албан хаагчдын ирц, ажлын цагийн нягтрал сайжирч анхааруулга авсан албан хаагчдын тоо 50%-иар буурсан бөгөөд журмыг дахин зөрчсөн албан хаагчдад хариуцлага тооцохоор төлөвлөн ажиллаж байна.</p> <p>- Хөрөнгө оруулалтын ажлын чанар үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахих чиглэлээр Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг чанд сахих ажиллаж байгаа байгаа бөгөөд тайлант хугацааны төсвийн гүйцэтгэлээр 62,0 сая төгрөгийг хэмнэсэн байна. Үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө 18,0 сая төгрөгөөр батлагдсан ба тайлант хугацаанд тендерийн баримт бичгийн орлогоос 50,2 сая төгрөг олж орлогын төлөвлөгөөг 32,2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.</p> <p>- Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” албан даалгаврын биелэлтийг хангах 2017 оны 11 сарын 03-ны өдөр төлөвлөгөөний хэрэгжилтийг <a href="http://monitoring.ub.gov.mn">http://monitoring.ub.gov.mn</a> цахим систем нийтлэн, 2017 оны 11 сарын 10-ны өдрийн 01/1810 тоот албан бичгээр холбогдох газарт хүргүүлээд байна.</p> <p>- 2017.01.19-ний өдрийн А/06 тоот тушаалаар “Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулсан.</p> <p>- “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, ажлын байранд хориглох зүйл, Худалдан авах ажиллагаанд төлөвлөх,</p>	
--	---	--

	<p>бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих болон бусад үүрэгтэй оролцож байгаа албан хаагчдад хориглох зүйлсийг нарийвчлан зааж 2017.02.20-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Давхар ажил эрхлэлтийн тухай хууль, журмын мэдээллийг байгууллагын мэдээллийн самбарт байршуулан, албан хаагчдад мэдээлэл өгөх, нийтийн албанд томилогдож буй албан хаагчдыг хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил үүрэг гүйцэтгэж буй эсэхтэй танилцан, шийдвэрлэж ажилласан.</li> <li>- Эрх бүхий албан тушаалтан шинэчлэгдсэн бүтцийн дагуу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргах хуулийн үйлчлэлд хамаарах 9 албан хаагчдад ХАСХОМ мэдүүлэх талаар сургалтыг 2017 оны 01-р сарын 19-ний өдөр зохион байгуулсан.</li> <li>- Хуулийн дагуу 2017 онд нийт давхардсан тоогоор 14 албан хаагч шинэчлэн буюу албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-ийг цахимаар мэдүүлж, цахимаар мэдүүлсэн мэдүүлгээ баталгааны маягтаар баталгаажуулан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.</li> <li>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.02.15-ны өдрийн 04/640 дугаартай “Тайлан ирүүлэх тухай” албан бичгийн дагуу Авлигатай тэмцэх газраас батлан хэрэгжүүлж байгаа дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгож, ХАСХОМ-1, ХАСХОМ-2 тайланг мэдүүлгийн системтэй уялдуулан үнэн зөв гаргаж 2017.02.23-ны өдөр хүргүүлсэн.</li> <li>- Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалаар батлагдсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журмын 4.2-т заасны дагуу эрх бүхий албан тушаалтан албан хаагчдын 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч, тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.</li> </ul>	
--	---	--

	<p>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2017.01.12-ны өдрийн 04/160 дугаартай “ХАСХОМ-ийг баталгааны маягтаар бүртгэж авах тухай” албан бичгийн дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолд орсон нэмэлт өөрчлөлт буюу уг тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан 3 төрлийн баталгааны маягтыг өөрийн байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>- Үнэлгээний хорооны гишүүд 473 удаад “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаж ажилласан ба уг мэдэгдлийг “shilendans.gov.mn цахим хуудаст тухай бүрт мэдээлсэн.</p> <p>- Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2017 оны 10-р сарын 03-ны өдөр тус газрын нийт албан хаагчдад “Авлигын мөн чанар, шалтгаан хор хөнөөл, авлига ашиг сонирхлын зөрчил, байгууллагын ил тод байдлыг хэрхэн хангах талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>- 2017.11.29–ний өдөр АТГ-ын 2017.10.04-ний өдрийн 01/7072 дугаартай зөвлөмжийн дагуу “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулинд 2017 оны 04-р сарын 13-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлт, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт буюу хуулийн 3 дугаар бүлэгт оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт”, мөн хуулийн 16-р зүйл бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт сэдэвт сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан.</p> <p>- Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт батлах тухай А/139 дугаар тушаалыг 2017.11.20 өдөр батлан байгууллагын нийт албан хаагчдаас “Нууцын баталгаа”-г гаргуулж ажилласан. Уг журмын 1 дүгээр хавсралтаар Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт, 2 дугаар хавсралтаар Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан</p>	
--	--	--

	<p>тушаалтныг зааж өгч ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018.01.15-ны дотор, 2017 оны ХАСХОМ-ын тайланг 2018.02.01-ний дотор НЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.</li> <li>- Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, хар жагсаалт гарган Сангийн яаманд бүртгүүлэх, дахин тендер шалгаруултад оролцуулахгүй байх арга хэмжээний хүрээнд тендерийн баримт бичгийг хуурамаар бүрдүүлж ирүүлсэн Үүний дүнд “Хансуун зам” ХХК, “Пи Си Эф” ХХК, “Биндэгноров” ХХК, “Тас Хайрхан” ХХК-уудыг хар жагсаалтад оруулахаар Сангийн яаманд 2017 оны 10 дугаар 13-ны өдрийн 02/1710 тоот албан бичгээр хүргүүлсэн.</li> <li>- Тендерийн баримт бичиг болон тендерт оролцогчоос ирүүлсэн саналын бүрэн бүтэн байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 онд 326 ширхэг лацыг ашиглаад байна.</li> <li>- Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг сугалааны зарчмаар санамсаргүй байдлаар сонгох аргыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</li> </ul>	
--	---	--

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)  
(тэмдэг)

..... / Э.БОЛОРМАА/

(гарын үсэг)

.....

тушаалтныг зааж өгч ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажилласан.

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2018.01.15-ны дотор, 2017 оны ХАСХОМ-ын тайланг 2018.02.01-ний дотор НЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлэхээр бэлтгэж байна.

- Худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, хар жагсаалт гарган Сангийн яаманд бүртгүүлэх, дахин тендер шалгаруултад оролцуулахгүй байх арга хэмжээний хүрээнд тендерийн баримт бичгийг хуурамаар бүрдүүлж ирүүлсэн Үүний дүнд "Хансуун зам" ХХК, "Пи Си Эф" ХХК, "Биндэгноров" ХХК, "Тас Хайрхан" ХХК-уудыг хар жагсаалтад оруулахаар Сангийн яаманд 2017 оны 10 дугаар 13-ны өдрийн 02/1710 тоот албан бичгээр хүргүүлсэн.

- Тендерийн баримт бичиг болон тендерт оролцогчоос ирүүлсэн саналын бүрэн бүтэн байдлыг хангах, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2017 онд 326 ширхэг лацыг ашиглаад байна.

- Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг сугалааны зарчмаар санамсаргүй байдлаар сонгох аргыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)  
(тэмдэг)

(гарын үсэг)



/ Э.БОЛОРМАА /